

СОЁМБО

БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТӨВ ХЭВЛЭЛ

2021.03.04 №09 (10738)

Үнэ 500 төгрөг

Дугаар эрхэлсэн ахмад М.МӨНХЗОРИГ



БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ-110 ЖИЛ

Ц.Шаравдорж: БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД НАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД БОДЛОГЫН ЗАЛГАМЖ ЧАНАР ЗАЙЛШГҮЙ ХЭРЭГТЭЙ

Батлан хамгаалахын сайд асан Ц.ШАРАВДОРЖТОЙ ярилцлаа.



тодорхой ярьсан. Төрийн шийдвэр гарч байгаа учраас Энэтхэгээс даруйдаа буцаж ирсэн дээ. Батлан хамгаалах салбарыг огт мэдэхгүй салбар гэж хэлэх нь юу юм, УИХ-ын гишүүнээр ажиллаж байх хугацаандаа Батлан хамгаалах салбарын хууль, эрх зүйн үндсийг бүрдүүлэх, гол үндэслэл болохуйц баримт бичгийг боловсруулах ажилд хуульчийн хувьд оролцон ажиллаж байсан туршлага байгаа учраас салбарын ерөнхий өнгө төрх, аж байдлыг гадарлахтайгаа байв. Ингээд Батлан хамгаалахын сайдын үүрэгт ажлыг хүлээн авах шийдвэрийг гаргасан.

Ажлаа хүлээж авсан тэр өдрийг тодорхой санаж байна. Сайдаар томилох тухай асуудал УИХ-ын холбогдох шат дамжлагаар орж, богино хугацаанд хурдан шийдэгдсэн. УИХ-ын нэгдсэн чуулганы хуралдааны шийдвэр оройхон гарсан ч тухайн үеийн Ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэгчтэй хамт Батлан хамгаалах яаманд хүрэлцэн очлоо. Хүндэт харуул үлээвэр хөгжимтэй хүндэтгэн угтаж авсан. Ингээд Батлан хамгаалахын сайдын үүрэгт ажлыг хүлээж авч, тамгаа гардан авсан даа.

Нэгэнт л сайдын үүрэгт ажилд томилогдсон тус салбарынхаа тухай төлөвлөх, үйл ажиллагаагаа хэрхэн яаж эхлүүлэх гээд бодох зүйл их.

(Үргэлжлэл нь II нүүрт)

ДУГААРЫН ЗОЧИН

Т.Анхатан: ЭЭЖИЙГЭЭ ХАЙРЛАХАД МАРГААШ ГЭЖ БАЙДАГГҮЙ

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалын Санхүүгийн хэлтсийн дарга, хурандаа Т.АНХАТАНГ энэ удаагийнхаа “Дугаарын зочин”-оор онцоллоо. Тэрээр Монгол Улсын Зэвсэгт хүчний хамгийн отгон эмэгтэй хурандаа юм.


Д.ОЮУНГЭРЭЛ

Таны бага насны дурсамжаас хоёул яриага эхлүүлье гэж бодлоо?

-Би бусад эмэгтэй цэргийн алба хаагчдын нэгэн адил жирийн нэг офицер, хүний хань, үр хүүхдийн ээж, сайн аавын охин. Аавыгаа дагаж машинных нь кабинд уйлсаар сууж, ажил руу очиж байсан тэр цагаас хойш цэргийн алба гэдэг миний хамгийн дотно орчин болсон. Миний бага нас цэргийн орчинд өнгөрсөн, хамгийн танил газар маань юм.

Тэгэхээр та чинь удам дамжсан цэргийн хүн байна шүү дээ?

-Тийм ээ. Миний аавыг Батдоржийн Төмөр гэдэг. 1971-1975 онд Цэргийн ерөнхий дээд сургуулийг автын мэргэжлээр төгсөж, Зэвсэгт хүчинд олон жил ажилласан хүн бий. Аав маань Монголын суудлын автомашины бартаат замын уралдааны улсын



анхны аварга бөгөөд энгийн болон цэргийн салбарт 2000 гаруй жолооч, бага мэргэжилтнийг сургаж бэлтгэсэн багш хүн бөгөөд өдгөө гавьяаныхаа амралтыг эдэлж, ач зээгээ тойруулан жаргаж сууна.

Хэдхэн хоногийн дараа эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах

өдөр тохионо. Ээжийнхээ талаар дурсаач?

-Ээж маань бурхан болоод 11 жил өнгөрчээ. “Ээжийгээ хайрлахад маргааш гэж байдаггүй” гэдэг үгийг өнгөрсөн хойно нь л ойлгосон. Хүн ер нь аливаа юмыг сүүлд ухаардаг юм байна. Ижийгээ баярлуулж чадсан бил үү гэж бодохоор гол зураад явчихдаг. Хань ижил, үр хүүхдийнхээ төлөө гэсэн ээжийн минь сэтгэл агуу байсан. Эрх зүйч мэргэжилтэй боловч намайг бага байхад эмч, багш, хуульч, сэтгэл зүйч, цагдаа гээд их олон мэргэжилтэй хүн шиг л санагддаг байлаа. Хүний дээд, амьдралын минь түшиг ээжийнхээ тухай дурсахад инээмсэглэл нь л хамгийн түрүүнд бууж байна. Ухаан орохоос эхлээд айлын бэр болтол минь хайрлаж өсгөрсөн их хайр нь үнэхээр агуу байсан.

(Үргэлжлэл нь IV нүүрт)



ЗЭВСЭГТ ХҮЧИН-100 ЖИЛ

Ц.Бямбажав: МОНГОЛ ЦЭРЭГ ЧИНГИСИЙН ЦЭРЭГ ГЭДГЭЭ БАТАЛСААР ЯВНА

Монгол Улсын Зэвсэгт хүчин хэмээх өнөр айл өрхөө татаж, өндөр босгоо дэвсэж, өргөн үүдээ нээгээд өдгөө нэгэн зууны түүхийн шаргал хуудсаа баринтаглаж байна. Туурга тусгаар орныхоо тулганд бадарсан галыг туждаа бөхөлж, хойчдоо өвлүүлэх эрхэм хүндтэй агаад асар хариуцлагатай үүрэг, амаргүй хүнд ачааг энэ салбараар овоглогдсон үе, үеийн хэн бүхэн нуруундаа үүрч явсан, үүрч ч яваа. Зэвсэгт хүчнийхээ хөгжил дэвшил, алсын хараа, ирээдүйн өнгө төрх, хэтийн бодлого зорилт, чиглэлийг тодорхойлоход оюун ухаан, сэтгэл зүрхээ зориулж, хувь нэмрээ оруулсан, оруулсаар яваа эрхмүүдийг бид 100 жилийн ойн босгон дээр уншигчидтайгаа “уулзуулж” байгаа билээ. Энэ удаа ЗХЖШ-ын дарга асан, дэслэгч генерал Ц.БЯМБАЖАВЫГ ярилцлагынхаа хойморт урилаа.



Д.МЭНДБАЯР

Орчин үеийн Зэвсэгт хүчний хөгжлийн чиг хандлага хэзээнээс улбаатай вэ?

-1992 онд батлагдсан Үндсэн хуульд “Монгол Улс өөрийгөө хамгаалах Зэвсэгт хүчинтэй байна” гэж тодорхойлсон. Энэ том зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Батлан хамгаалах болон Зэвсэгт хүчний ирээдүйн хөгжлийг хуульчлан тодорхойлох зайлшгүй шаардлага үүссэн учраас үүнээс улбаалаад “Батлан хамгаалах тухай хууль” болон эрх зүйн бусад баримт бичгүүдийг боловсруулж эхэлсэн. Эдгээр ажлыг цоо шинээр эхлүүлэх үүрэг Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний бүрэлдэхүүнд ноогдсон юм.

Батлан хамгаалах тогтолцооны бүх хууль, эрх зүйн үндэс, “Төрийн цэргийн бодлогын үндэс” баримт бичгийг УИХ-аар батлуулснаар цомхон чадварлаг, мэргэжлийн чиг баримжаатай Зэвсэгт хүчинтэй байна хэмээн тодорхойлж, “Төрийн цэргийн бодлогын үндэс” баримт бичгийг боловсруулан батлуулсан Батлан хамгаалахын сайд асан Д.Дорлигжав, Төрийн нарийн бичгийн дарга, дэслэгч генерал Ц.Дашзэвэг нарын хичээнгүй, хөдөлмөрч, уйгагүй ажиллагаа, тэдний хичээл зүтгэлийн үр дүнд өнөөдрийн Зэвсэгт хүчний хөгжлийн эх суурь тавигдсан гэдгийг онцлон тэмдэглэхийг хүсэж байна.

(Үргэлжлэл нь III нүүрт)

ТӨРЛИЙН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ НАР ТОМИЛОГДЛОО



УИХ-ын 2020 оны хаврын ээлжит чуулганаар Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдаж, шинээр төрлийн гурван цэрэг байгуулагдсан билээ. Зэвсэгт хүчний бүтцэд Хуурай замын цэргийн командлал, Агаарын цэргийн командлалаас гадна шинээр Тусгай хүчний цэргийн командлал, Кибер аюулгүй байдлын цэргийн командлал, Барилга-инженерийн цэргийн удирдах газар байгуулагдсан юм. Хууль, эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Ерөнхийлөгчийн зарлигаар Тусгай хүчний цэргийн командлагчаар хурандаа Б.Баатар, Кибер аюулгүй байдлын цэргийн командлагчаар хурандаа Д.Баасандамба нар томилогдсон ЗХЖШ болон төрлийн цэргийн командлалын бүрэлдэхүүнд энэ сарын 2-нд ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг танилцуулж, баяр хүргэлээ.

Хошууч генерал Д.Ганзориг “Мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчнийг бэхжүүлэх ажил шат дараатай явагдаж байна. Үүний нэг нь яах аргагүй шинээр байгуулсан төрлийн цэргийн командлал, удирдах газраа байгуулж, томилоогжуулан ажил үүрэгт нь оруулж байгаа явдал юм” гээд шинээр томилогдсон командлагч нарт хандаж, “Нэн хариуцлагатай үүрэг та бүгдийн өмнө байна. Шинэ төрлийн цэргийг эхнээс нь эмхлэн зохион байгуулах, бүрдүүлж бэхжүүлэх үйлсэд тань амжилт хүсье. Аливаа ажлыг эхлүүлэх төвөгтэй, бас ээдрээтэй. Манай Зэвсэгт хүчний төрлийн цэргийн шинэ дарга нар энэ ажлыг огт түүртэлгүй хийж чадна гэдэгт итгэл төгс байна. Бид ч бүх талаар дэмжинэ” гэлээ.

“СОЁМБО” СОНИН “ДҮҮ”-ТЭЙ БОЛЛОО

Батлан хамгаалах яамны 110, Зэвсэгт хүчний 100, Монгол хүн сансарт ниссэний 40 жил, БХЯ-ны харьяа байгууллагууд, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын түүхт ойн босгон дээр “Соёмбо” сонины хамт олон “Соёмбо-Мэдээ” өдөр тутмын цахим сонины анхны дугаараа 2021 оны 03 дугаар сарын 03-нд өлгийдөн авлаа.

Өдөр тутам нийтлэгдэх уг сониноос уншигч Та бүхэн Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний хэмжээнд өрнөсөн ажил, арга хэмжээний талаарх мэдээ мэдээллийг БХЯ, ЗХЖШ, ҮБХИС-ийн вэб сайт, “Соёмбо” сонины пэйж хуудсаар дамжуулан цаг тухайд нь хүлээн авч унших боломж бүрдэж байна.

Өөрөөр хэлбэл, 97 жилийн түүхтэй “Соёмбо” сонин “дүү”-тэй болж байгаа юм.





БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ-110 ЖИЛ

Ц.Шаравдорж: БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД НАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД БОДЛОГЫН ЗАЛГАМЖ ЧАНАР ЗАЙЛШГҮЙ ХЭРЭГТЭЙ

(Түрүүч нь I нүүрт)

Маргааш өглөө нь удирдлагын бүрэлдэхүүнийг хүлээн авч уулзан, гол ажлуудын талаар мэдээлэл сонсож, үйл ажиллагаагаа эхлүүлж байжээ. Дараа нь анги, байгууллагуудаар их явсан. Салбар, нэгжүүдийн удирдлага, бие бүрэлдэхүүнтэй уулзаж санал бодлыг нь сонсоход ихээхэн анхаарч байлаа. Ялангуяа хөдөөгийн анги, салбарууд дахь офицер, ахлагч нарын амьдрал нэлээд хүнд байсныг тэр үед л мэдэрч байгаа юм. Жишээ нь, Эрдэнэтийн хороонд очиход уулзсан нэг ахлагчийг сайн санаж байна. Булан нь элэгдсэн хэдэн чөмөдөн, чанар муу, зүсгүй шахам болсон орноос өөр хогшилгүй байсан. Тухайн үед тэр ахлагч "Би олон анги дамжсан, амьжиргаагаа дээшлүүлэх боломж олдоогүй, өгсөн үүрэг даалгаврыг л биелүүлж явна" хэмээн учирлахад их өрөвдөж билээ. Хотод буцаж ирээд офицер, ахлагч нарын нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэхэд онцгой анхаарах ёстой гэдгийг Сайдын зөвлөлд анхааруулж тодорхой асуудлыг хэлэлцүүлж байлаа.

Та УИХ-аар бодлогын баримт бичгүүдийг батлуулахад идэвхтэй ажилласан. Баримт бичиг батлагдсанаар ямар ахиц гарсан бэ?

-УИХ-ын гишүүнээр ажиллаж байхад ажлаа сайн мэддэг, арвин баялаг туршлагатай, миний найз нөхдүүд болох Хилийн цэргийн командлагч, хошууч генерал Д.Базарсад, сүүлд ҮБХИС-ийн захирлаар ажиллаж байсан, хошууч генерал Н.Жалбажав нарын олон эрхэмтэй хамт хууль тогтоох чиглэлд хамтарч ажилласнаараа бахархдаг. Сайдаар ажиллаж байх үед эдгээр хүмүүсээс авахуулаад тухайн үеийн Төрийн нарийн бичгийн дарга, дэд сайд, яамны газар, хэлтсийн дарга, ЗХЖШ-ын удирдлагуудтайгаа зөвлөлдөж, бид үнэхээр гар сэтгэл нийлсэн хамт олон болж ажиллаж байлаа. Ер нь аливаа салбарын үйл ажиллагаа хэвийн явагдах нь тухайн салбарын үйл ажиллагааг зохицуулсан хууль, эрх зүйн үндэс хэр сайн боловсрогдож батлагдсанаас ихээхэн шалтгаалдаг юм. Хуульч хүний хувьд Батлан хамгаалах салбарын үйл ажиллагааг зохицуулсан хууль, тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулахдаа өмнөхөөсөө улам боловсронгуй болгох, шинэ нөхцөл байдалд зохицсон хэм хэмжээг шинэчлэн найруулах талаар нэлээн ажилласан гэж боддог.

Таныг сайдаар ажиллаж байх үед БХЯ-ны гадаад хамтын ажиллагааны бодлого хэрхэн хэрэгждэг байсан бэ?

-Дэлхийн зарим улс орнуудын өөрийн болон бүс нутагт явуулж байгаа бодлого үйл ажиллагаа үндсээрээ өөрчлөгдөж, тухайн бүс нутгийн аюулгүй байдлыг хамтын хүчээр зохицуулах, үүнд улс төр дипломатын аргыг шавхан дайчлах, харилцан хамтын ажиллагаа явуулах зайлшгүй шаардлага тулгарсан цаг үед бид ажиллаж байлаа. Би сайдаар ажиллах үедээ хэд хэдэн орны Батлан хамгаалах салбарын удирдлагуудтай ажил хэргийн уулзалт яриа хийж, хамтын ажиллагааны чиглэлээр санал бодлоо солилцож ажилласан. Тухайлбал, АНУ-ын Батлан хамгаалахын сайд Доналд Рамсфелдтэй хоёр ч удаа уулзсан. Эхлээд Сингапурт Ази-Номхон далайн бүсийн орнуудын Батлан хамгаалах сайд нарын зөвлөгөөний үеэр, дараа нь АНУ-ын Батлан хамгаалахын сайдын Монгол Улсад хийсэн айлчлалын үеэр уулзаж, хоёр орны Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны асуудлаар яриа хэлэлцээ хийж байв. Олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр тус уулзалтын тухай "Хоёр улсын Батлан хамгаалахын сайд нар салбарын хамтын ажиллагааны талаар маш чухал асуудлуудыг хөндлөө" гэх агуулгатай мэдээллүүдийг цацаж байлаа.

АНУ-ын Батлан хамгаалахын сайдын айлчлал болж өнгөрснөөс сар гаруйн дараа тус улсын Ерөнхийлөгч Ж.Буш Монголд айлчилсан. Тэрээр онгоцны буудалд газардсан даруйдаа "Танай Батлан хамгаалахын сайдын ноён Рамсфелдэд бэлэглэсэн морийг үзэхээр ирлээ" хэмээн нарги болгож байсан нь АНУ-тай тогтоосон Батлан хамгаалах салбарын хамтын



ажиллагаа их ойр байх эхлэлийг тавьжээ гэж бодоход хүргэдэг. Америкчууд, НАТО-гийн түнш орнуудтай ойр харилцаатай байсны хүчинд энхийг дэмжих ажиллагаанд оролцох бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийн материаллаг баазыг бэхжүүлэх, тухайлбал "Таван толгой" дахь энхийг сахиулагчдын сургалтын төвийг өргөтгөх, шинэчлэн төхөөрөмжлөх ажлын эхлэл энэ үед тавигдсан юм.

Монгол Улсын Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний гадаад харилцааг өргөтгөх, үр өгөөжтэй болгох, ялангуяа Монгол Улсын цэрэг, цагдаагийн алба хаагчдын НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцох чадварыг нэмэгдүүлэх, оролцоог нь өргөтгөх, нөхцөл боломжийг сайжруулах талаар хичээж ажилласан.

Нэг зүйлийг тэмдэглэхэд, АНУ-ын Батлан хамгаалахын сайд Доналд Рамсфелд "Танай улсын энхийг сахиулагчид хүлээсэн үүргээ нэр төртэй, сайн гүйцэтгэж байгаа. Дайны аюул нүүрлэсэн дэлхийн халуун цэгт үүргээ хэрхэн гүйцэтгэж байгааг та өөрийн биеэр харвал зүгээр юм" хэмээн зөвлөж билээ. Уг саналыг ажил хэрэг болгож тодорхой баг бүрдүүлэн Кувейтээр дамжин Иракт очсон. Польшийн цэргүүдийн байрлаж буй объектод үүрэг гүйцэтгэж буй энхийг сахиулагчдаа эрхэ үеэрээ АНУ-ын цэргийг командалж буй генералтай уулзсанаа сайн санаж байна. Нэг зүйлийг зориуд тэмдэглэхэд, монгол дайчид дэлхийн халуун цэгт үүрэг гүйцэтгэхдээ хэний ч өмнө нүүр улайхааргүй үлгэр жишээчээр бусад орны цэргүүдэд өмөг түшиг болж байсныг өөрийн нүдээр харсан. АНУ болон Польшийн генерал, офицерууд "Монгол цэргүүд үүрэг гүйцэтгэж байхад бид сэтгэл амар, бүтэн нойртой хонодог" гэж хэлж байсныг ч тод санаж байна. Тэр ч бүү хэл "Түгшүүрийн дохио өгөхөд монгол улбаатай монгол хүний цусанд ийм зүрх, зориг бий болсон юм. Бидэнд энэ бол нэг их сонин зүйл биш" гэж хариулж байлаа. Бас "Монгол цэрэг хэзээ ч хажуу дахь нөхрөө хаядаггүй юм" хэмээн "бардамнаж" билээ.

Алба хаагчдын нийгмийн хамгааллын асуудал бүхий л цаг үеийн сайд нарын тулгамдсан асуудал байсаар ирсэн байх?

-Энэ нь сайдаар ажиллаж байсан бүх хүний анхаарлын төвд байдаг, байсаар байх асуудал. Офицер, ахлагч, цэргүүдийнхээ төлөө анхаарахгүй бол өөр юуг анхаарах юм бэ. Өмнө нь хэлсэнчлэн салбарын хууль, эрх зүйн үндсийг боловсронгуй болгоно гэдэг нь офицер ахлагч нарын нийгмийн асуудал, үйл ажиллагааг төгөлдөржүүлэх, хуулийн дагуу шийдвэрлэх боломжийг

Таны Иракт ажилласан багт сэтгүүлч зураглаач багтсан нь энхийг сахиулагчдыг бодитоор сурталчилсан ажил болсон гэж боддог?

-Зэвсэгт хүчин их даруухан салбар. Төрийн өмнө хүлээсэн тусгай үүрэгтэй, энэ үүргээ биелүүлэхээс биш, өөрсдийгөө сурталчлаад байдаггүй онцгой салбар. Дэлхийн халуун цэгт манай улсын Зэвсэгт хүчний алба хаагчид бусад улсын цэрэгтэй мөр зэрэгцэн алба хаана гэдэг маш том үйл явдал. Үүнийг олон нийтэд ойлгуулах, иргэдэд монгол цэргүүдээрээ бахархах сэтгэгдэл төрүүлэх боломж тэр үед олдсон. Үүний үндсэн дээр UBS телевизийн сурвалжлах багийнхныг авч явж баримтат кино хийж, энхийг сахиулагчдынхаа үйлс гавьяаг нийтэд харуулж мөнхжүүлж чадсан гэж боддог.

Ирак явахдаа тэнд алба хааж байгаа энхийг сахиулагчдынхаа аав ээж, амраг хайртаас нь явуулсан захиа, мэндийг тарааж, цэргүүдтэйгээ сонин хуучилж, халуун яриа өрнүүлсэн дээ. Маргааш нь террористуудын халдлагыг няцааж, монгол цэргийн нэр хүндийг өндөрт өргөсөн Г.Азаяа, Ш.Самбуу-Ёндон нарын зогсож байсан харуулын цамхаг, тэсрэх бөмбөгтэй амиа золиослогчдыг тээвэрлэсэн машиныг устгахад үүссэн дэлбэрэлтийн том нүхийг өөрийн биеэр очиж үзсэн. Харуулын цамхаг, бөмбөг тээвэрлэсэн машин хоёрын хоорондын зай чамгүй хол юм билээ. Манай хоёр залуу аргагүй л онь холбож, гайхамшигтай онч мэргэн буудлагыг үзүүлсэн байсан. Баазын захад хашааны тэнд болсон дэлбэрэлтээс үүдэж хашаан доторх бүх байшингийн цонх хагарсан байсан гэнэ. Үүнийг хараад үнэхээр их огшиж, бид найдвартай хөвгүүдээ дэлхийн халуун цэгт илгээдэг, тэд нар маань маш хүнд нөхцөлд алба үүргээ амжилттай гүйцэтгэдэг юм байна гэж бодож билээ. Сонин болгож ярихад, манай цэргүүд Монголоос авахсан УАЗ-469 машинаа монгол аргаар хуягласан байгаа юм. Бусад улс орны цэргүүд тусгай тоноглолоор тоноглогдсон машин, техник ашигладаг бол манайхан өөрсдийн гар, ур ухаанаар хуяглаж аюулгүй ажиллагааны горимыг нь бий болгосон гээд үзүүлж байлаа. Монгол цэргүүд хаана ч байлдах, хүнд нөхцөлд дасан зохицож байлдааны үүргээ биелүүлэх чадвартай юм байна гэсэн бодол тэр үед өөрийн эрхгүй төрж байсан шүү. Польшийн цэргийн командлалын офицеруудын гайхширлыг харин ч нэг төрүүлсэн байсан. Энэ бол гайхалтай дурсамжтай, гайхамшигтай бахархал минь болж үлдсэн.

Гар сэтгэл нийлж ажилласан баг, хамт олныхоо талаар дурсвал?

-Ажил үүргээ гүйцэтгэж, нэг хамт олон болж ажилласан бүх нөхдөө нэрлэж, дурсмаар байвч бүгдийг тоочиж яхин барах билээ. Батлан хамгаалахын сайд Ц.Шаравдорж үүргээ сайн гүйцэтгэж байсан гэвэл эдгээр хүмүүсийн л ач тус.

Дэд сайд Б.Эрдэнэбат, хошууч генерал С.Баасанхүү, М.Борбаатар, Ч.Улаанхүү, шижигнэсэн сайхан залуучууд болох хурандаа Г.Сайханбаяр, Н.Энхбаяр гэдэг нэрлээд байвал олон хүн байсан даа.

Би чинь хоёр сайхан зөвлөхтэй ажиллаж байсан сайд шүү дээ. Генералын шинэхэн мөрдөс зүүсэн Н.Жалбажав маань Батлан хамгаалах салбарын тухай гүн мэдлэгтэй, шуурхай, ажил хэрэгч хүн. Нөгөө зөвлөх маань Доржготов хурандаа. Энэ хүнийг би генералын энэтэй хурандаа гэж боддог, тэгж ч манайхан ярьдаг байсан. Тэр бээр генерал цолны болзлыг хоёр удаа хангасан юм билээ. Тийм мэдлэгтэй офицер байдаг гэдгийг Доржготов хурандаагаас л анх удаа харж байсан. Энэ хоёр маань надад мөн ч их түшиг тулгуур, нөмөр нөлөг болсон доо.

Танд жилээс илүү ажиллах хугацаа байсан бол тийм л ажлыг хийж байсан даа гэж боддог зүйл байдаг уу?

-Бодож санасан юм их байсан. Тухайн үеийн БНХАУ-ын Батлан хамгаалахын сайдын урилгаар тус улсад айлчилсан юм. Хятадын БХЯ-ны удирдлагууд бидэнд чухал гэсэн объектуудаа танилцуулж, уулзалт маш ойр дотно, найрсаг уур амьсгалд болж өнгөрсөн. Батлан хамгаалахын сайд нь хуучнаар ЗХУ-ын цэргийн сургуулийг их бууны мэргэжлээр төгссөн, оросоор

чөлөөтэй ярьдаг хүн байж таарсан. Миний хувьд ЗХУ-д сургууль төгссөн учраас бид хоёрын яриа орос хэлээр өрнөж, хэлмэрчгүйгээр нарийн ширинээ ярилцах боломж олдсон. Ингэхдээ өөрийн биеэр хэд хэдэн хүсэлт тавьсан. Жишээлбэл, анги, салбаруудын техникийн хангалт муухан байсан тул Зэвсэгт хүчний бүх ангийн удирдлагуудыг тус улсад ашиглагдаж буй сүүлийн үеийн автомашинаар хангах хүсэлтээ илэрхийлсэн. БНХАУ-ын Батлан хамгаалахын сайд "Энэ асуудлыг шийдэж өгнө, та эх орондоо очоод санал хүсэлтээ бидэнд уламжлаарай. Хоёр талаасаа асуудлыг нарийвчлан ярилцъя" гэдгээ ч хэлж байсан. Харамсалтай нь биднийг Монголд ирсний дараахан Засгийн газар огцорч би ажлаа хүлээлгэн өгөх болсон. Дараагийн хүмүүс маань үүнийг сайн ойлгосонгүй юу, яасан юм бол, тэр ажил бүтээгүй юм билээ.

Хоёрдугаарт Батлан хамгаалах салбарын харьяанд барилгын материал үйлдвэрлэлийн маш том объект байсан. Тус объект Зэвсэгт хүчний тэжээл, бид цаашдаа улсаас төсөв авахгүй, аж ахуйн үйл ажиллагааныхаа орлогоор өөрсдийгөө санхүүжүүлэх бүрэн боломжтой, барилгын материалаар Зэвсэгт хүчнээ хангахаас гадна Монгол Улсыг хангана гэсэн ирээдүйг харж тооцоо судалгаагаа хийж эхлээд байсан. Монгол Улсад бүтээн байгуулалт хэрхэн өрнөж байгаа билээ, тэдгээрийг хангах барилгын материалын хэрэгцээ ямар их байгааг бид урьдчилан харж ийм ирээдүйг бодож төлөвлөж эхэлсэн юм. Тиймээс тэр баазыг удирдаж ажиллуулах боловсон хүчнийг нь хүртэл томилчихсон байлаа. Засгийн газар огцорсон нь нэг их сонин биш. Үүнд харамсаад байх юм байхгүй, нэг л улс төрийн шийдэл хэрэгжсэн нь тэр. Харамсалтай нь дараагийн хүмүүс энэ ажлыг хэрэгжүүлэхгүйг би өнөөдөр хэлэх ёстой. Одоо тэр объект хувийн хэвшилд очихсон. Үүнд би дэндүү харамсдаг. Улсын төсвөөс мөнгө гүйхгүйгээр Зэвсэгт хүчнээ бүрэн санхүүжүүлэх боломж бидэнд байсан юм шүү дээ.

Төрийн бодлого, үйл ажиллагааны залгамж халаа ямар чухал болохыг таны яриа сануулж байна. Тиймээс сургаж болгож хэдэн үг хэлэхгүй юу?

-Монгол Улсын хууль тогтоох үйл ажиллагааны залгамж чанар гэж том зүйл байх ёстой. Өнөөдрийн байдлаар УИХ улс орны хэмжээнд дагаж мөрдөх олон чиг хуулийг баталсан. Бүх салбар хуультай болсон. Гэтэл УИХ шинээр бүрдэхээр л хуулиар оролдодог. Энэ нь нэг талаас сайн хууль батлагдах ёстой гэсэн шаардлага байж болох ч, нөгөө талаас шинээр УИХ-д орж ирсэн хүмүүс өөрийн болон бусад сонирхол, эрх ашгийг эн тэргүүнд тавьж хуульд халдах нь сайн зүйл биш. Батлан хамгаалах салбарын хууль тогтоомж харьцангуй тогтвортой гэж би хувьдаа боддог. Үүнийг миний өмнө болон хойно ажиллаж байсан Батлан хамгаалахын сайдуудын ажлын үр дүн гэж хардаг. Ер нь Батлан хамгаалахын сайд нарын үйл ажиллагаанд бодлогын залгамж чанар зайлшгүй хэрэгтэй. Улс төрөөс хамгийн ангид байх салбар бол Батлан хамгаалах салбар.

Та тухайн үед Батлан хамгаалахын улсын зөвлөгөөнийг санаачлан зохион байгуулсан. Түүнээс гарсан бодлогын шинж чанартай зүйл юу байв?

-Олон жил тийм арга хэмжээг зохион байгуулалгүй байсаар Улсын зөвлөгөөнтэй золгосон. Батлан хамгаалах салбарын хэвийн үйл ажиллагаа, нийгэм, эдийн засгийн бааз, суурийг бэхжүүлэх, хууль эрх зүйн үндсийг шинэчлэх, цаашид яаж хөгжих зураглалаа тодорхойлохоор сайтар хэлэлцсэн зөвлөлтөөр болсон. БХЯ, БСШУЯ, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Хилийн ба Дотоодын цэргийн удирдлага, бусад төлөөллийн өргөн хүрээг хамарсан зөвлөгөөнийг хийснээрээ бид хоосон. Батлан хамгаалах салбар асуудалтай юм байна, түүнийгээ шийдэх бодлоготой, бодлого нь ингэж хэрэгжинэ, хэрэгжүүлэхэд төр тус салбарыг анхаарах ёстой гэдгийг бид гаргаж харуулж чадсан. Энэ зөвлөгөөний ач холбогдол үүнд байсан болов уу гэж бодож байна. Зөвлөгөөний шийдвэрийг биелүүлэх олон ажил зохиогдсон шүү дээ, үр дүн ч гарсан.

(Түрүүч нь I нүүрт)

Энэ үеэс цэргийн шинэчлэл гэдгийг маш эрчимтэй хэрэгжүүлж, зоригтой шийдвэрүүд гаргасан. Тэдгээрийн нэг нь БХЯ, ЗХЖШ гэж хоёр тусдаа байгууллага байх ёстой гэдэг шийдэл. БХЯ нь төрийн захиргааны төв байгууллага, ЗХЖШ нь цэргийн мэргэжлийн дээд байгууллага юм. Энэ баримтлалыг хөтөлбөртөө тусгаад албан ёсоор зарласан, энэ бүтцээр ч явсан. Түүнчлэн Зэвсэгт хүчин гэдэг айл бие даасан үйл ажиллагаа явуулах ёстой гэдэг ЗХЖШ-ыг бие даасан тамга тэмдэгтэйгээр агентлагийн статусаар ажиллуулсан.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Н.Багабанди Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг дэмжиж, дээр дурдсан хууль эрх зүйн заалтуудыг хэрэгжүүлж, ЗХЖШ-ын даргыг өмнө нь Батлан хамгаалахын сайд томилдог байсан бол Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн зарлигаар ЗХЖШ-ын даргаар томилогдсон анхны хүн нь генерал Ц.Дашзэвэг. Ингээд үндсэндээ Зэвсэгт хүчний өмнө маш тодорхой зорилго, зорилт дэвшигдсэн. Би их тод санадаг юм. 1999 оны 10 дугаар сард болсон удирдах бүрэлдэхүүний цугларалтад Ерөнхий сайд М.Энхсайхан оролцож үг хэлсэн. Юу гэж хэлэв гэхээр "Хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээ, зорилтуудыг чинь дэмжиж байна Дорлигжав сайд аа, Зэвсэгт хүчинд залуу үе өөрийн эрхгүй татагддаг тийм уур амьсгал, орчин бүрдүүлэх хэрэгтэй. Монгол цэргийг харсан гадныхан үнэхээр Чингисийн монгол цэрэг мөн байна гэж хэлэхээр тийм түвшинд хүргэхийн төлөө бид бүхэн ажиллах ёстой" гэсэн юм. Энэ нь үнэхээр манай салбарынхныг урамшуулж, зоригжуулсан бас тодорхой зорилго өөд хөтөлсөн гайхалтай үзэл санаа байсан. Энэ үг хэллэг, үзэл санааг тухайн цаг үедээ нэг хэсэг хүмүүс хүлээн зөвшөөрөхгүй биелэгдэшгүй мөрөөдөл гэж ярьж шүүмжилж байсан. Гэтэл өнөөдөр эргээд харахад Монгол Улсын Зэвсэгт хүчний бүрэлдэхүүн, монгол цэрэг энхийг сахиулах ажиллагааны чиглэлээр дэлхийд данстай, аргагүй л Чингисийн монгол цэргүүд мөн байна гэдгээ батлан харуулж явна гэдгийг Ерөнхий сайд асан М.Энхсайхан танд сониноор дамжуулан хэлэхэд таатай байна.

ЗХЖШ-ын даргын харилцаатай албан тушаалд томилогдоход танд юу бодогдож байсан бэ?

-Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Ц.Элбэгдорж маш тодорхой чиглэл өгсөн. Тодруулбал, Зэвсэгт хүчин өмнөө тавьсан зорилтоо хэрэгжүүлэх бүрэн чадвартай байх, түүнд чиглэсэн бодитой ажлуудыг хийх хэрэгтэй. Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүний хүнтэй харилцах харилцаа, соёл, ажлын арга барилд өөрчлөлт гаргах, бүх шатны захирагч, дарга нар ёс зүйн өндөр түвшинд байх ёстой шүү гэсэн нь миний ажлын удирдамж болсон.

ЗХЖШ гэдэг том айлд тодорхой албан тушаалуудыг хашиж байсан маань, мөн АНУ-ын Төв командлал (CentCom USA)-д олон улсын энхийг сахиулах ажиллагаатай холбоотой асуудлаарх үйл ажиллагааг удирддаг командлалд ажиллаж, олон улсын цэрэг-улс төрийн нөхцөл байдал, энхийг сахиулах ажиллагааны бодит байдал, ирээдүйн хандлагыг тодорхой түвшинд ойлгож, мэдэрсэн зэрэг нь ЗХЖШ-ын даргын албан тушаалыг хашихад харьцангуй нэмэр болсон.

Та ажлаа аваад Зэвсэгт хүчний бүтцийг "J"-гийн удирдлагын тогтолцоонд шилжүүлсэн. Ингэх зайлшгүй шаардлага байсан уу? Таны төлөвлөсөн үр дүнд хүрч чадсан уу?

-Зэвсэгт хүчний бүрэлдэхүүн энхийг сахиулах ажиллагаанд оролцсон тодорхой туршлагатай, нэр хүндтэй болсон нь цаашид НҮБ-ын мандаттай энхийг сахиулах ажиллагаанд оролцоход "J"-гийн системд шилжих шаардлага үүссэн. Ер нь энэ систем зөвхөн энхийг сахиулах ажиллагааны оролцоогоор хязгаарлагддаг тогтолцоо биш. Мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчнийг хөгжүүлэхэд ч ач холбогдол бүхий тогтолцоо гэж үзсэн. Тус системийн амин сүнс нь багаар ажиллаж, харилцан бие биедээ итгэл хүлээлгэн өмнөө тавьсан зорилтоо хэрэгжүүлж чаддаг оршдог. Энэ шаардлагын үүднээс офицер, ахлагч нарын үүрэг гүйцэтгэх чадварыг дээшлүүлэхэд



ЗЭВСЭГТ ХҮЧИН-100 ЖИЛ

Ц.Бямбажав: МОНГОЛ ЦЭРЭГ ЧИНГИСИЙН ЦЭРЭГ ГЭДГЭЭ БАТАЛСААР ЯВНА



Бүх цэргийн Их хар сүлдийг цэнгүүлэх ёслол. 2011 он



АНУ-ын Штабын дарга нарын нэгдсэн хорооны дарга, генерал Х.Дэмпсийн хамт

нэлээд анхаарал хандуулсан. Юуны өмнө Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүн болон анги, байгууллага, нэгжийн дарга, захирагч нартай илэн далангүй ярилцаж ойлголцохыг хичээсэн. Шударга ёсыг эрхэмлэх, харилцан итгэлцэх, ойлголцох, дэмжих гэсэн дөрвөн зарчмыг баримталж ажилласан. Зэвсэгт хүчнийг мэргэжлийн чиг баримжаатай, чадварлаг болгон хөгжүүлэхийн тулд офицер, ахлагч нарын боловсролын түвшин, үүрэг гүйцэтгэх чадвар, бие бялдрын хөгжил, ёс суртахууны төлөвшил зэрэг асуудлуудад шалгуур тавьж, сургаж бэлтгэхийг зорьсон.

Зэвсэгт хүчний хөгжил дэвшилд таны оруулсан хувь нэмэр, гүйцэтгэсэн үүргийн талаар тодруулбал та юуг онцолж хэлэх вэ?

-Өнөөдөр Монгол Улсын Зэвсэгт хүчин 100 жилийн ойтойгоо золгож байна гэж үзээд эндээс хөөвөл би 53 жилийнх нь ой дээр хугацаат цэргийн албанд ирж байж. Тэр үеийн нисэхийн 137 дугаар ангид байлдагч, бүр нарийн яривал, Миг-17 онгоцны радио электроны хэрэгслийн механик цэрэг байлаа. Ингэж л Зэвсэгт хүчинтэй ажил амьдралаа холбох эхлэл тавигдан, шан татагдаж энэ салбарын халуун тогоонд 41 жил "буцалж" дээ. Эх орныхоо төлөө тангараг өргөсөн цэрэг эрстэй мөр зэрэгцэж, олон сайхан хүнээс суралцаж, хамтарч ажилласны үр дүнд Зэвсэгт хүчиндээ чадах хэмжээгээрээ хувь нэмэр оруулахыг хичээж иржээ. Миний бие 1996 онд Улсыг агаарын довтолгооноос хамгаалах цэргийн командлагчаар томилогдсон. 1990 оноос өмнө ЗХУ-ын Зэвсэгт хүчний оролцоотойгоор Монгол Улсын агаарын хил, агаарын орон зайгаа хянах хамтын тогтолцоотой байсан. Зөвлөлтийн цэрэг Монголоос гарснаар Зэвсэгт хүчний өмнө тэр тусмаа Улсыг агаарын довтолгооноос хамгаалах цэргийн хувьд бие даан агаарын хилээ хянах, агаарын орон зайгаа хамгаалах шаардлага үүсэж, энэ нь гол зорилго, зорилт болсон юм.

Хэдийгээр эдийн засаг туйлын хүнд байсан ч эх орныхоо төлөө өргөсөн тангарагтай цэргийн хүний хувьд Зэвсэгт хүчнээ яаж хөгжүүлэх вэ, ямар хувь нэмэр оруулах вэ гэж зүрх тархи, сэтгэл оюунаа чилээх нь бидний үүрэг шүү дээ. Тийм ч учраас гараа хумхийд эсвэл алгаа

тосоод зүгээр суугаагүй. Батлан хамгаалахын сайд, ЗХЖШ-ын дарга нарын шийдвэр, даалгаврыг биелүүлж, Улсыг агаарын довтолгооноос хамгаалах цэргийг хөгжүүлэхэд чиглэсэн тодорхой ажлуудыг хийсэн. Тухайлбал, Зэвсэгт хүчний 325, 326 гэсэн хоёр хороо, Говь-Алтайн Алтай, Ховдын Булган, Увсын Зүүнговь, Дорнодын Сүмбэрт тусгай салбаруудыг цоо шинээр байгуулсан. Өмнөговийн Манлайгаас Ханбогд, Дорнодын Матадаас Дорнодын төв рүү хоёр салбарыг шилжүүлсэн гэхчлэн шинээр хийсэн бодит ажил чамлахааргүй бий. Эдгээр нэгжийг шинээр байгуулж, шилжүүлэн байрлуулсан нь Монгол Улсын агаарын орон зайн хяналтыг нягтруулан сайжруулахад чиглэгдсэн чухал ажлууд байсан юм.

ЗХЖШ-ын удирдлагын бүрэлдэхүүн Эзэн Чингисийн үеэс монгол цэрэг эрсийн манлайд залагдаж ирсэн уламжлалт Бүх цэргийн Хар сүлдийг Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний оройн дээд сүлд болгон залсан. Хар сүлдийг цэнгүүлж байсан газар, байрлалыг өөрчилж, Чингис хааны үр садын өсөж өндийсөн түүхэн дурсгалт эх сурвалж бүхий өндөрлөгт цэнгүүлдэг болсон.

Нэг баг болон ажилласан Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүнийхээ хичээнгүй, шаргуу хөдөлмөрийн үр дүнд олон улсын энхийг сахиулах ажиллагаанд мянга мянган монгол цэргийг илгээж үүрэг гүйцэтгүүлжээ. Өвөг дээдсийнхээ үүх түүхээр бахархаж омогшсон, онож төрсөн монгол эх орноо хайрлах үзэл санаа нэвт шингэсэн, тусгаар тогтносон ардчилсан Монгол Улс минь хөгжин дэвшсэн улс орон байгаасай гэдгийг гадаадад үүрэг гүйцэтгээд ирсэн цэрэг дайчид маань хэлдэг. Үүнийг сонсоод эх орноо хайрлан хамгаалах үзэлтэй, монголоороо бахархсан иргэн төлөвшил байгаад баярлаж явдаг. Түүнчлэн төр засгийнхаа шийдвэрийг хэрэгжүүлэн улс орныхоо бүтээн байгуулалтад оролцож, хөхөө өвлийн хүйтэн, хөр цасны хайрууд ядарч шантрахыг үл ажран уулыг нурааж засмал зам, усыг гэтэлгэн гүүр, улсын шаардлага стандартыг хангасан барилга, байгууламжуудыг барьж офицер, ахлагч, цэргийн алба хаагчдынхаа ажиллаж, амьдрах ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлэхийн төлөө

ажиллаж чаддаг цэрэг дайчдаа хараад монгол хүн юу ч хийх чадвартай юм байна гэдэг итгэл үнэмшилтэй болсон. Аливаа үйлсийн хөгжил дэвшлийн эхлэл суурийг зөвөөр тавьж, зөв чиглэлд оруулахад анхдагч удирдагч, хамт олны хичээл зүтгэл туйлын ач холбогдолтой байдагчлан НҮБ-ын мандаттай олон улсын энхийг сахиулах ажиллагаанд Төв Африкийн Бүгд Найрамдах Чад улсад үүрэг гүйцэтгэсэн хурандаа Л.Онцгойбаяр /бригадын генерал/ захирагчтай хамт олон, Суданы Дарфурт үүрэг гүйцэтгэсэн дэд хурандаа Т.Сүхбаатар /Хурандаа/ захирагчтай хамт олон, Афганистанд АНУ-ын Зэвсэгт хүчинтэй хамтран үүрэг гүйцэтгэсэн ахмад Д.Жавхланбаяр /Хурандаа/ захирагчтай хамт олон, Афганистанд ХБНГУ-ын Зэвсэгт хүчинтэй хамтран үүрэг гүйцэтгэсэн ахмад С.Болдбаатар /Хурандаа/ захирагчтай хамт олон, Афганистанд Бельги Улсын Зэвсэгт хүчинтэй хамтран үүрэг гүйцэтгэсэн хошууч Г.Хатанбаатар /дэд хурандаа/ захирагчтай хамт олон, Афганистанд үүрэг гүйцэтгэсэн дэд хурандаа Ч.Болдбаатар /бэлтгэл хурандаа/ захирагчтай Нисдэг тэрэгний сургагч багийн хамт олонд талархаж явдгаа илэрхийлж.

Түүнчлэн нэг баг болон ажилласан Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүний захирагч, дарга нарын санал санаачилга, идэвх зүтгэлийн үрээр Зэвсэгт хүчний үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэх хүрээнд УИХ-ын тогтоолоор батлагдсан тусгай хэрэгцээний газарт болон стратегийн ач холбогдолтой барилга, байгууламж, объектыг барьж байгуулах зориулалт бүхий Зэвсэгт хүчний 338, 339, 340, 350, 353 дугаар ангиудыг шинээр байгуулж, 017, 084, 119, 123, 189, 232, 256, 284, 311, 325, 326, "Алдар" спорт хороо гэсэн анги, байгууллагуудыг шинэчлэн сайжруулж, нөхцөл бололцоог нь нэмэгдүүлэх чиглэлээр гэхчлэн бидний хамт олны хийсэн бодит ажил олон бий.

Офицер, ахлагч нарын мэргэшсэн чадвар, ялангуяа, ахлагч нарыг мэргэшүүлэхэд анхаарлаа хандуулж, АНУ-ын ахлагчийн коллеж төгсөөд ирсэн залуусыг түлхүү ашигласан, үр дүнгээ ч

өгсөн. Өнөөдөр манай ахлагч нар харьцангуй боловсролтой, мэргэшсэн ахлагч нар болсон. Тэд үүргээ амжилттай гүйцэтгэж, Зэвсэгт хүчний гол цөм болж явна. Мөн хугацаат цэргийн алба хаагчдад ч анхаарал хандуулсан. Барилга инженерийн ангиудыг түшиглэж Хөдөлмөрийн яамтай хамтраад хугацаат цэргийн алба хаагчдад төрөл бүрийн мэргэжил олгох ажлыг эрчимтэй хийсний үр дүнд тодорхой асуудал шийдэгдээд явсан.

Зэвсэгт хүчний ирээдүйг та хэрхэн төсөөлж байна вэ?

-Үндсэн хуульд туссан "Монгол Улс өөрийгөө хамгаалах Зэвсэгт хүчинтэй байна" гэсэн том зорилт бүрэн дүүрэн утгаараа хэрэгжинэ гэдэгт итгэлтэйгээр өөдрөг харж байна. Зэвсэгт хүчин Хуурай замын цэрэг, Агаарын цэргээс бүрдэж байж Монгол Улсынхаа өргөн уудам нутаг дэвсгэр, агаарын орон зай, агаарын хилийг хамгаалах мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчинтэй байх тухай нэг биш удаа хэлэлцүүлэг явуулсны үндсэн дээр Ерөнхий зориулалтын цэргийн командлал, Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн командлагуудыг бие дааж үүрэг гүйцэтгэх үзэл санаагаар эхний түвшинд бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулах гэх мэт эхлэлийг тавьсан. Хожим нь Зэвсэгт хүчний тухай хуулийн шинэчлэлээр Хуурай замын цэрэг, Агаарын цэрэг мөн Кибер аюулгүй байдлын цэрэг, Тусгай хүчний цэрэг, Барилга-инженерийн цэргээр өргөжин тэлж байна. Энэ бол Зэвсэгт хүчний ирээдүйн хөгжлийг тодорхойлсон эрх зүйн орчин бүрдэж байгаа юм. Зэвсэгт хүчин өөрийн нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хамгаалахад чиглэсэн орчин үеийн шаардлагад нийцсэн зэвсэглэл, техниктэй болох нь зайлшгүй. Хамгийн чухал зүйл бол офицер, ахлагч нарын мэдлэг боловсрол, дадлага туршлагыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн, өөрөөр хэлбэл, бүрэлдэхүүнийг хөгжүүлэхэд чиглэсэн тасралтгүй сургах хөтөлбөртэй байх хэрэгтэй. Байгууллагын хөгжил хүний хөгжлөөс хамаардаг. Тэгэхээр хүнээ хөгжүүлэхэд чиглэсэн ажлыг түлхүү хийх хэрэгтэй. Гадаад дотоодод сургууль дамжаа төгсөх амархан. Харин сурч мэдсэнээ Монголын хөрсөнд, Зэвсэгт хүчнийхээ хөгжлийн зөв хандлагад нийцүүлж байнга сурч, судалж, сонсож байх нь их чухал. Хайрцагласан сэтгэлгээ хувь хүний болон байгууллагын хөгжлийг чөдөрлөдөг. Цэргийн алба бол багаар ажилладаг, багаар ажиллаж байж үр дүнд хүрдэг онцлогтой учир залуус багаар ажиллаж сурах ёстой.

Батлан хамгаалах салбарын гадаад харилцаа өргөжиж байгаатай уялдаад Зэвсэгт хүчний гадаад хамтын ажиллагаа, хамтарсан дадлага, сургууль, харилцан бие биеэсээ суралцахад Зэвсэгт хүчний удирдах албан тушаалтан болон офицер, ахлагч нарт гадаад хэл тэр тусмаа орос, англи, хятад хэлний мэдлэг чадвар зайлшгүй шаардлагатай. Зэвсэгт хүчний бүрэлдэхүүнээс дэлхийн өндөр хөгжилтэй улс, орнуудад суралцаж суралцагчдын тоо өсөн нэмэгдэхэд Батлан хамгаалахын сайд болон ЗХЖШ-ын дарга нарын гүйцэтгэх үүрэг өндөр байдаг. Миний бие БНХАУ, ОХУ, АНУ, ХБНГУ, Энэтхэг, Австрали, БНТУ, Израил, Бельги зэрэг орны Жанжин штабын дарга нарын урилгаар айлчилж, хоёр орны цэргийн хамтын ажиллагаа болон энхийг сахиулах ажиллагаанд оролцохтой холбоотой яриа хэлцүүдийг хийж байсан.

Ярилцлагынхаа төгсгөлд та юу хэлэх вэ?

-Зорилго зорилт, санал бодол нэгдэж нэг баг болон хамтран ажилласан Зэвсэгт хүчний удирдлагын бүрэлдэхүүн, захирагч, дарга нар та бүхний хичээл зүтгэл, хөдөлмөрийн үр дүнгээр нүдэнд харагдаж, гарт баригдах чамгүй ажил биеллээ олж, хэрэгжиж байгаад талархан Та бүхэндээ Зэвсэгт хүчний 100 жилийн ойн баярын мэнд дэвшүүлж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсье.

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД С.К.ШОЙГУ ЭЛЧИН САЙД Д.ДАВААГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАВ



ОХУ-ын Батлан хамгаалахын сайд С.К.Шойгу энэ сарын 1-нд Монгол Улсаас ОХУ-д суугаа Элчин сайд Д.Давааг хүлээн авч уулзав.

Уулзалтаар хоёр орны цэрэг-техникийн хамтын ажиллагааны тулгамдсан

асуудлуудыг хэлэлцэж, мөн хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоосны 100 жилийн ой, Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойн хүрээнд хамтран зохион байгуулах зарим

арга хэмжээний талаар санал солилцлоо. Энэ үеэр С.К.Шойгу Монгол Улсын Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүнд удахгүй тохиох орчин цагийн Зэвсэгт хүчний 100 жилийн ойн баярын мэндийг хүргэсэн юм.

ДУГААРЫН ЗОЧИН

Т.Анухатан: ЭЭЖИЙГЭЭ ХАЙРЛАХАД МАРГААШ ГЭЖ БАЙДАГГҮЙ

(Түрүүч нь I нүүрт)

Бидний багад их хатуу хүн байсан. Манайх 3 охинтой айл. Би дундах нь. Эгч ууган нь, дүү отгон нь гээд их эрх. Хамаа ажил над дээр буудаг байлаа. Сахилгагүй, хөдөлгөөнтэй хүүхэд байсан болоод тэр байх. Мөн чамгүй банга хүртэнэ шүү. Манай нөгөө хоёр туранхай, эмэгтэйлэг, би жаахан эршүүд маягтай. Тэр ч утгаараа авыгаа дагаад цэргийн хүн болсон байх. Багадаа мөрдөн байцаагч эсвэл нисгэгч болно гэж мөрөөддөг байлаа. Би 6 дугаар ангид байхаасаа машин барьж, аавын калибр буугаар буудаад сурчихсан байсан.

эж загнаад учрыг нь тайлбарлаж, тэгээд л ЦИС-ийн Ерөнхий зориулалтын цэргийн сургуулийн ерөнхий цэргийн ангид элсэн орж байлаа. Хоёрдугаар дамжаанаасаа ар тал, эдийн засгийн ангид шилжин суралцаж 2000 онд төгссөн. Зэвсэгт хүчинд 25 дахь жилдээ алба хааж байна.

Халшрах үе байв уу?

-Халширч байсан үе ёстой байгаагүй. Сургуулийн багш нар сонгогчдыг эрэгтэй байна уу, эмэгтэй байна уу гэж ерөөсөө ялгахгүй. Тийм болохоор эрчүүдтэйгээ эн зэрэгцээд үзээд байдаг байсан. Эндээс би юу олж авсан бэ гэхээр "Би эмэгтэй, би даарна, ядарна" гэсэн ойлголтыг

нэг хүний зураг хоёр байхыг харж байгаагүй. Ангийн захирагч хурандаа Ж.Дүүрэнжаргал ганц эмэгтэй хүнийг бардаггүй гээд ангийн офицеруудад их уурлаж билээ. Ажлын анхны гараа маань ингэж дардан эхэлж байлаа. Үүнээс хойш 2000-2005 онд Зэвсэгт хүчний 032 дугаар ангид Хүнс, хувцасны албаны даргаар, 2005-2016 онд ЗХЖШ-т Цэргийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах алба буюу одоогийн Хяналт, шинжилгээ, үнэлгээний газрын Санхүүгийн хяналтын хэлтэст санхүүгийн хяналтын улсын байцаагчаар, 2017-2018 онд Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Санхүүгийн хэлтэст төсвийн офицероор, 2018-

ХУРАНДАА НАР ЧУУЛЛАА



"Хурандаа" цол олгож эхэлсний 85 жилийн ойг тохиолдуулан "Монгол хурандаа" нийгэмлэг ТББ-аас энэ сарын 2-нд "Монгол Улсын цэргийн цолны үүсэл замнал-хурандаа цолтон" онол практикийн бага хурлыг зохион байгууллаа. Тус нийгэмлэгийн дэд тэргүүн, профессор, хурандаа Д.Баярхүү хурлыг нээж үг хэлсний дараа мөн нийгэмлэгийн Ерөнхий менежер, магистр, хурандаа Л.Амарсайхан "Монгол Улсын цэргийн цолны үүсэл замнал-хурандаа цолтон" сэдвээр үндсэн илтгэлийг хэлэлцүүлсэн юм.

"Эх орны тусгаар тогтнол, эх орон, газар нутгийн төлөө тэмцэж байсан эрлэхг хурандаа нарын түүхэн замнал" сэдвээр тус нийгэмлэгийн УЗ-ийн гишүүн, Хил хамгаалах байгууллагын хурандаа нарын Салбар зөвлөлийн дарга, магистр, хурандаа Д.Мөнхбат, "Улсын аюулгүй байдлыг хангахад хүчин зүтгэсэн хурандаа нарын түүхэн замнал, тэдгээрийн цол, дүрэмт хувцасны онцлог" сэдвээр ТЕГ-ын ажилтан, судлаач, хошууч Н.Батболд, "Хүн ардын амар тайван амьдралын төлөө зүтгэсэн хурандаа нарын дайчин замнал" сэдвээр доктор /Ph.D/, цагдаагийн хурандаа Х.Түвшинжаргал, "Монголын утга зохиол, урлагт хурандаа цолтны нийтлэг дүр төрх, баатарлаг, хөдөлмөрч зан чанарыг тодорхойлсон нь" сэдвээр судлаач, бэлтгэл дэд хурандаа М.Бямбарагчаа нарын хүмүүс нийт долоон хавсралт илтгэлийг хэлэлцүүлж, сонирхолтой яриа өрнүүлэв.

анхны эмэгтэй хурандаа цолтон нь.

Хурандаа цолоо гардаг авах үе хөл хориотой цагаар таарсан. Тиймээс эрдэлээс шалтгаалаад хот руу ирэхгүйгээр "Хуурай замын цэргийн командлагчийг цолыг нь гардуулаарай" гэсэн болохоор Төв аймагт командал дээрээ цолоо гардаг авсан. Онжавуудыгаа ирэхгүй нь гэж бодож байтал бүгд хамрагдах ёстой шинжилгээгээ өгөөд олуулаа шаагилдаад ороод ирэхэд маш их баярлаж байлаа.

Зэвсэгт хүчинд эмэгтэй цэргийн алба хаагч хурандаа цол хүртэнэ гэдэг нэр төрийн хэрэг. Цолоо зүүж байх агшинд юу бодогдож байв?

-Их догдолсон. Үгээр хэлэмгүй сайхан мэдрэмж төрж байсан. Эж минь тэнгэрээс харж ихэд бахархаж, баярлаж байгаа даа гэж эрхгүй бодогдсон. Энх тунх байхдаа "Аавынхаа авч чадаагүй цолыг миний охин аваарай" гэж хэлж байсан нь санагдаад цолоо гардаг байхдаа золтой л уйлчихаагүй.

Та буудлагын спортод багагүй амжилт гаргасан байх аа?

-Би буудлагын спортод их дуртай. Ажлын ачааллаас шалтгаалаад энэ спортоо цааш

Зэвсэгт хүчний 032 дугаар ангид хамт ажиллаж байсан. Бид охин, хүүтэй. Миний ар талыг сайн дааж, үр хүүхдүүдээ анхаарч ажил албыг минь хүндэлж, дэмжиж явдаг хандьаа баярлалаа гэж хэлэв.

Хурандаа маань хэр сайн гэрийн эзэгтэй вэ?

-Өөрийгөө гайгүй л гэж боддог шүү. Сайн хань, сайхан ээж байхын төлөө аль болох хичээдэг. Гэхдээ хүүхдүүдийнхээ даалгаврыг хийлгэхээрээ их ширүүн ээж болчихдог.

Таны амьдралдаа баримталдаг зарчим юу вэ?

-Аливаад шударга хандахыг хичээдэг. Дарга ч бай, цэрэг ч бай ялгалгүй тэгш хандахыг илүүд үзнэ. Хүнтэй ялгаж харьцах дургүй, тийм араншинтай хүмүүс надад таалагддаггүй. Мэдээж албаа нэр төртэйгээр гүйцэтгэхийг хичээдэг.

Тэмдэглэж байсан эмэгтэйчүүдийн баяруудаас сэтгэлд тод үлдсэн нь аль нь вэ? Дурсамжаасаа хуваалцахгүй юу?

-Бодоод байсан, эмэгтэйчүүдийн баяр гэхээсээ илүүтэй цэргийн баяраараа эрчүүдтэйгээ хамт баярлачихдаг юм байна. Гэхдээ хамт олон минь юу гэж зүгээр байх вэ. Хэзээд



Насаараа бид нэг ангийнхан

Мөрдэстэй бүсгүй болох сонголтод авын нөлөө их байсан нь анзаарагдаж байна?

-Тэгэлгүй яах вэ. Өөрийн хүсэл сонирхол ч байсан. Есдүгээр ангид ордог жил ЦИС-ийн харьяа лицей анги нээгдэж таарсан. Тэр үед аав ээж хоёр ОХУ-д байсан ч санаандгүй байдлаар орчихсоноо тод санаж байна. Лицей төгсөөд ЦИС-д шалгалтгүйгээр элссэн. Сургууль төгсөх үед нэг дэд хурандаа орж ирээд "Офицерын сургуульд орох уу, ахлагчийн сургуульд орох уу" хэмээн асуухад ялгааг нь сайн мэдэхгүй болохоор хурдан төгсөх юм байна гэж ойлгоод ахлагчийн сургуульд орохоор саналаа өгч билээ. Харин

тархинаасаа авч хаяж чадсан. Эргээд бодоход амьдралд минь ч их хэрэгтэй чанар болж төлөвшөн.

Ажлын гараагаа хаанаас эхлүүлж байв?

-2000 онд Зэвсэгт хүчний 032 дугаар ангиас эхлүүлсэн. Олон жилийн түүхтэй бахархам, бусдаас онцлогтой анги шүү. Их ч мундаг дарга нартай, олон жилийн арвин туршлагатай хамт олонтой ажиллаж байлаа. Захирагч, ар талын дарга, нягтлан нярвуудаасаа олон зүйлийг сурсан. Нэг сайхан дурсамж дэлгэхэд, 2002 онд ангийн хүндэт самбарт миний зураг хоёр удаа тавигдсан. Нэг нь оны аварга, нөгөөх нь оны аварга буудагч гээд. Би ер нь хүндэт самбарт

2019 онд Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалын санхүүгийн хэлтэст санхүүгийн ахлах офицероор, 2019 оны 11 дүгээр сараас мөн командлалдаа Санхүүгийн хэлтсийн даргаар томилогдон ажиллаж байна.

Таны онжавуудын талаар асуухгүй өнгөрч болохгүй нь?

-Манай онжавууд нэг нэгнийхээ жаргал зовлонгийн аль алинд хамт явдаг. Өдгөө бүгд нэгэн жигд амжилттай яваад баярлаж, тэднээрээ бахархдаг. Энэ жил манай онжавууд 25 жилийн ойгоо тэмдэглэх төлөвлөгөөтэй байгаа. Нөхөрлөлийн 25 жилийн ой ч гэж нэрлэж болно. Миний хувьд онжавуудынхаа 29 дэх бөгөөд

нь хөгжүүлж, тэмцээн уралдаанд төдийлөн оролцоод байж чаддаггүй. Аавыгаа дагаад хүүхэд байхаасаа л калибраар буудаж сурсан. Зэвсэгт хүчний цэрэгжлийн буудлагын аварга шалгаруулах тэмцээний гар бууны тогтоол болон хурдан буудлагын төрлөөр хэд хэдэн медаль хүртсэн. Хэрэв багаасаа бэлдсэн бол өдийд чамгүй сайн буудагч болсон байх гэж боддог.

Ингэхэд та гэр бүлээ танилцуулахгүй юу?

-Миний ханийг Б.Гантулга гэдэг. Төрийн тусгай хамгаалалтын газарт ажилладаг. Дэд хурандаа цолтой. Төрийн гурван өндөрлөгийн хамгаалалтад 16 дахь жилдээ ажиллаж байгаа мундаг залуу бий.

Нэг сайхан дурсамж дэлгэхэд, 2002 онд ангийн хүндэт самбарт миний зураг хоёр тавигдсан. Нэг нь оны аварга, нөгөөх нь оны аварга буудагч гээд. Би ер нь хүндэт самбар дээр нэг хүний зураг хоёр байхыг харж байгаагүй. Ангийн захирагч хурандаа Ж.Дүүрэнжаргал ганц эмэгтэй хүнийг бардаггүй гээд ангийн офицеруудад их уурлаж билээ. Ажлын анхны гараа маань ингэж дардан эхэлж байлаа.

бидэнд гэнэтийн бэлэгтэй байдаг. Хяналт, шалгалт, үнэлгээний газар ажиллаж байхад "Мартын 8"-аар урлагийн тоглолт зохион байгуулж, миний нууцлагдмал авьяасыг нээн илрүүлж байсан нь сэтгэлд хоногшин үлджээ.

Нийт бүсгүйчүүддээ хандаж мэндчилгээ дэвшүүлэхгүй юу?

-Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчинд ажиллаж байгаа нийт эмэгтэй офицер, ахлагч, ажилтан, алба хаагчид болон эр цэргүүдийнхээ найдвартай ар тал болсон халамжит бүсгүйчүүддээ Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийн амьжил мэндийг хүргэж, аз жаргал, баярлалт бүтээлийн дээдийг хүсэн өрөөв.

Ш.Бүд: МОНГОЛЫН ҮНЭРТЭЙ САЛХИ ГЭЖ ҮНЭХЭЭР Л БАЙДАГ ЮМ БИЛЭЭ

Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад явагдаж буй НҮБ-ын мандаттай UNMISS энхийг сахиулах ажиллагаанд Монгол Улсын Зэвсэгт хүчний Х ээлжийн батальон үүрэг гүйцэтгэж буй. Уг батальоны эмч, дэслэгч Ш.БҮДИЙГ Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг угтан урьж ярилцлаа.

Д.ОЮУНГЭРЭЛ

Та манай уншигчдад өөрийгөө танилцуулахгүй юу?

-Зэвсэгт хүчний төв хэвлэл "Соёмбо" сониныг шимтэн уншдаг мөрддэг нэгт нөхдөдөө алс холын Африк тивээс мэндчилж, энэ өдрийн амрыг тань эрье. Миний алдрыг Шаравын Бүд гэдэг. Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургуулийг 2013 онд хүний их эмч мэргэжлээр төгссөн. Анагаах ухааны магистрын зэрэгтэй. Цэргийн төв эмнэлгийн Яаралтай тусламж, мэдээгүйжүүлэх эрчимт эмчилгээний эмнэл зүйн төвд мэдээгүйжүүлэг, цус трансфузиологи судлалын эмчээр ажилладаг.

Анх онгоцноос буухад тань ямар сэтгэгдэл төрж байв? Энэ таны оролцож буй хэд дэх ажиллагаа вэ?

-Би анх удаа энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байна. Сурагч байхаасаа л "Цэнхэр дуулганы эгнээнд багтаж дэлхийд данстай цэрэг болох юм сан" гэсэн гэгээхэн мөрөөдөлдөө хөтлөгдсөөр өнөөдөр зорьсондоо хүрчээд цэргийнхээ сонинд энхийг сахиулагч бүсгүйчүүдээ төлөөлөн ярилцлагаа өгч байгаадаа туйлын их баяртай байна.

БНӨСУ-д үүрэг гүйцэтгээд ирсэн алба хаагчдаас үлгэр домог шиг олон сонин, содон яриа сонсож байсан. Мөн энэ газар, ажиллагааны талаарх телевизийн нэвтрүүлэг үзэж байсан учраас тодорхой төсөөлөлтэй хөл тавьсан. Анх онгоцноос буухад дотор давчдам бүгчим газар угтсан. Урт амьсгаа авах гэсэн ч чадаагүй. Тэр мөчид Монголын үнэртэй салхи гэж үнэхээр байдаг юм байна гэж бодогддог юм билээ. Бодит байдалтай бол хол зөрөөгүй.

Өмнөд Суданд нөхцөл байдал ямар байна вэ? Танай баг ажиллагааны газар оронд ямар үүрэг гүйцэтгэж байна вэ?

-БНӨСУ-д хуурай улирал ид дундаа, хүн амын хөл хөдөлгөөн ихтэй байна. Цагийн байдал харьцангуй тогтвортой ч дэлхийг хамарсан цар тахлын үед ажиллаж байгаа тул илүү анхаарал шаардаж байна. Цэргийн багийн хувьд тус улсдаа хамгийн томд тооцогдох 100 мянга орчим хүнтэй дотоодын дүрвэгсдийн



болон UNMISS ажиллагааны штабаас өндрөөр үнэлж байгаад баяртай байгаа.

Тантай хамт хэдэн эмэгтэй цэргийн албан хаагч очсон бэ?

-Манай багт 53 бүсгүй мөр зэрэгцэн үүрэг гүйцэтгэж байна. Миний хувьд хамт ирсэн бүсгүйчүүдийнхээ цэргийн эрдэм, ухаанаас маш ихийг сурч, дотно сайхан найзууд болж байна.

Үүрэг гүйцэтгэж байгаа газар тань бусад орны эмэгтэй цэргийн алба хаагч хэр олон байна вэ?

-Ажиллагааны газар оронд олон орны бүсгүйчүүд үүрэг гүйцэтгэж байна. Харамсалтай нь цар тахалтай холбоотойгоор тэр бүр уулзаж ярилцах боломж хязгаарлагдмал байна. Үүрэг гүйцэтгэх хугацаанд багийн ажиллагаа, цэргийн хэргийн мэдлэгээ илүү сайжруулж, гадаад хэлний мэдлэгээ дээшлүүлэх зорилтыг өмнөө тавьсан.

Цэргийн хүн байхын давуу болон хэцүү тал юу вэ?

-Хүн бүрийн хүсээд орж чадахгүй албанд эмэгтэй хүн үүрэг гүйцэтгэх нь маш том бахархал, магадгүй бага зэрэг бардамнал байх. Төрийнхөө алтан соёмбыг тэргүүндээ залж, дүрэмт хувцсаа өмсөөд жагсаалдаа алхах нь үнэхээр сайхан. Цэрэг аав, эмч эзжийн охин хос мэргэжил, хоёр тангарагтай цэргийн бүсгүй болсондоо өөрөөрөө ихэд бахархдаг. Харин хэзээ л бол хэзээ тушаал аваад үүрэг гүйцэтгэхээр гэр бүлээ, үр хүүхдээ орхиод гарах нь ээж хүн, эхнэр хүний хувьд үнэхээр хэцүү санагддаг.

хүнсээр гачигдаж, сургуульд суралцаж чадахгүй, тэр бүү хэл 10-хан настай жаал хүү буу бариад явж байгааг харах өр өмөрмөөр байдаг.

Өмнөх энхийг сахиулагчдын жишээнээс харахад эх орноо хайрлах сэтгэл илүү батаждаг шиг санагддаг. Эх орон, тусгаар тогтнолын тухай таны бодол юу вэ?

-Монгол хүн ямар ч айх айдасгүй, эргэлзэх зүйлгүйгээр уудам хөх тэнгэрийн дор аяар амгалан аж төрж байна. Нүдээ аниад эх орноо бодоход зүйрлэмгүй тансаг мэдрэмж төрдөг. "Бид ямар их хувь заяагаар Монголынхоо газар шороон дээрээ хүн болж төрөө вэ" гэж бодож тайтгардгаа нуух юун.

Эх орныхоо өглөө, үүрэг гүйцэтгэж байгаа орон хоёрынхоо өглөөг нэг харьцуулаач. Харьг очоод хамгийн түрүүнд юу хийнэ гэж төлөвлөж байна вэ?

-Гэртээ өглөө сэрээд хөшгөө нээхэд цэлмэг хөх тэнгэр, цэнгэг агаар, алтан шаргал наран мэлтийж, тэртээ уулсын орой суунаглан харагдах нь хэчнээн их тэнүүн уужим билээ. Хүний нутаг их л давчуу санагддаг. Монгол хүн өөрөө байгаль дэлхийтэйгээ их ойрхон амьдардаг. Гэтэл үүрэг гүйцэтгэж байгаа газар орны онцлог нь уул нурууд байдаггүй. Тиймээс Монголд очоод хамгийн эхэнд гэр бүлээрээ ууланд алхана даа.

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг үүрэг гүйцэтгэж байх хугацаандаа тэмдэглэх нь. Монголд байхдаа баяраа хэрхэн тэмдэглэдэг байсан бэ?



хуаран, НҮБ болон олон улсын хүмүүнлэгийн байгууллагын өмч хөрөнгийг хамгаалах, ажилтан, албан хаагчдын аюулгүй байдлыг хангахын сацуу байнгын байрлалаас 80 гаруй км-ийн зайд орших Маёом сууринд эргүүлийн үүрэг гүйцэтгээд хоёр сарын нүүр үзэж байна.

Энэ хугацаанд бид НҮБ-ын цэрэг төдийгүй хүмүүнлэгийн тусламж сүүлийн 5-10 жилд хүрч очоогүй тийм газруудаар эргүүл, цувааны хамгаалалтын үүрэг гүйцэтгэлээ. Үүнийг орон нутгийн иргэд төдийгүй НҮБ

Хүнд хэцүү газар оронд амьдарч байгаа хүүхэд, эмэгтэйчүүдийг харахад юу бодогддог вэ? Танай багийн зүгээс хүүхэд эмэгтэйчүүд рүү чиглэсэн ямар тусламжийн ажиллагаа өрнүүлж байна вэ?

-Ядуу буурай орны иргэн болсон нь тэдний буруу биш ч гэлээ зарим үед үнэхээр сэтгэл шимширмээр дүр зурагтай таардаг. Амьдарч байгаа орчин нөхцөл, орон байр, хоол хүнс гээд бүгдийг бурхан мартсан гэлтэй санагддаг. Эх хүний хувьд хүүхдүүд нь бохир заваан нөхцөлд өсөж, хоол

-Урьд өмнө нь шинэ жил, цагаан сар гээд олон баярыг гэр бүл, найз нөхөд, хамт олныхоо хүрээнд тэмдэглэн өнгөрүүлдэг байсан. Энэ удаад +50 хэмийн халуунд, олон эрчүүд дунд 50-аад эмэгтэй баяраа тэмдэглэж байгаа нь их сонин содон тохиол болж байна. Ингээд тун удахгүй тохиох Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийн мэндийг хамтран үүрэг гүйцэтгэж буй батальоны бүсгүйчүүдээ болон Цэргийн төв эмнэлгийн хамт олондоо өргөн дэвшүүлье. Та бүгдийн үйлс өөдөө, үргэлж инээмсэглэж явахыг хүсье.

Манай улсын 800 ЭМЭГТЭЙ ЭНХИЙГ САХИУЛАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦЖЭЭ

Хүн төрөлхтний түүхэнд анхны төрт улсыг үндэслэн байгуулж, хүчирхэгжүүлэн мандуулж, өргөн уудам тал нутагт нүүдэллэн аж төрж байсан монголчуудын аугаа их эзэнт гүрнийг эмхлэн байгуулахад хатан ухаант эрэлхэг дайчин бүсгүйчүүдийн оруулсан хувь нэмэр үлэмж их билээ.

• 2006 оноос хойш НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд манай улсын 800 гаруй эмэгтэй цэргийн алба хаагч үүрэг гүйцэтгэжээ. Энэ нь НҮБ-ын шугамаар ажиллаж буй дэлхийн 126 улсаас нийт энхийг сахиулагчдын тоогоор 26, эмэгтэй цэргийн алба хаагчдын тоогоор 17, нэг хүнд ноогдох энхийг сахиулагчдын тоогоор манай улс Ази тивдээ тэргүүлж байна.

• Хамгийн анхны эмэгтэй энхийг сахиулагч бол ЗХЖШ-ын Цэргийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга, хурандаа Н.Нямжаргал юм. Тэрээр 2006 онд ахмад цолтой байхдаа НҮБ-ын Баруун Сахар дахь MINURSO энхийг сахиулах ажиллагаанд нэг жилийн хугацаатай цэргийн ажиглагчийн үүрэг гүйцэтгэсэн.



• Тэр цагаас хойш Баруун Сахар дахь MINURSO, БНӨСУ-ын Абией мужид явагдаж буй НҮБ-ын UNISFA ажиллагаанд нийт 34 эмэгтэй цэргийн алба хаагч цэргийн ажиглагчаар, Бүгд Найрамдах Судан Улсын Дарфур мужид явагдаж буй UNAMID, Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад явагдаж буй UNMISS ажиллагааны Хүчний төв штаб болон бусад оронд 22 эмэгтэй цэргийн алба хаагч штабын офицерын үүргийг гүйцэтгээд байна.

• Энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн нийт цэргийн алба хаагчийн 4, мотобуудлагын батальоны 7, олон улсын ажиллагаанд оролцож буй цэргийн хамгаалалтын ротын 5 хувийг тус тус эмэгтэй цэргийн алба хаагч эзэлж байна.

• НҮБ-ын Энхийн ажиллагааны газар (DPO)-ын Цэргийн харилцааны хэлтэст Монгол Улсын Зэвсэгт хүчнээс 2015 онд анх удаа дэд хурандаа цолтой мэргэжилтнээр үүрэг гүйцэтгэхээр томилогдсон офицер нь хурандаа Г.Болор байв. Тэрээр одоо Тайванд суралцаж байна.



• НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн "Эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдал" тогтоолын хэрэгжилтийг хангахын тулд НҮБ-ын Энхийн ажиллагааны газар 2018 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн "НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй эмэгтэй цэргийн алба хаагчдын тоог 15 хувьд хүргэх тухай" албан даалгаврыг цэрэг хандивлагч нийт улс оронд хүргүүлсэн. НҮБ-ын гишүүн орны хувьд уг тогтоолын хэрэгжилтийг хангахаар ажиллаж буй улсын нэг нь Монгол Улс юм.

• 2008-2011 онд Сьерра Леон Улсад явагдсан НҮБ-ын UNMIL ажиллагаанд 43 эмэгтэй цэргийн алба хаагч, 2010-2017 онд Бүгд Найрамдах Судан Улсын Дарфур мужид явагдсан НҮБ/АХ-ны хамтарсан UNAMID ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй цэргийн хэргийн 2 дугаар шатны эмнэлгийн багт 238 эмэгтэй цэргийн алба хаагч үүрэг гүйцэтгэжээ. UNMISS ажиллагаанд 2012 оноос хойш 431 энхийг сахиулагч үүрэг гүйцэтгэсэн бөгөөд яг одоо 54 эмэгтэй Африк тивд энхийг сахиулж байна.

• ИБНАУ-д ХБНГУ-тай хамтран үүрэг гүйцэтгэж буй Монгол Улсын цэргийн хамгаалалтын ротын бүрэлдэхүүнд 2018 оноос 30 эмэгтэй цэргийн алба хаагч үүрэг гүйцэтгэсэн. Яг одоо 6 бүсгүй энхийг сахиулж байна.





Т.ИДЭР

Анх хэрхэн дохионы хэлийг сурсан бэ? Энэ хэлийг сурах ямар шалтгаан байв?

-Үнэнийг хэлэхэд би 17 нас хүртлээ сонсголгүй иргэд байдгийг мэддэггүй байсан. Тухайн цаг үед тэдэнд зөвхөн би биш, нийгмээрээ төдийлөн анхаарал хандуулдаггүй байсныг гэж хожим ойлгосон. Би уг нь оёдлын технологич мэргэжилтэй. Намайг оюутан байхад манай сургуулийн нэгдүгээр давхарт сонсголгүй залуус хамтраад хивс, ороолт зэрэг гар урлалын бүтээл нэхдэг жижиг цех ажиллуулдаг байлаа. Тэдний хоорондоо дохионы хэлээр харилцаж байхыг хараад, ямар хүмүүс дохиогоор харьцдаг юм бэ хэмээн ихэд гайхаж, сончуурч байснаа санаж байна. Тэгж л би анх сонсголгүй иргэдтэй харьцаж үзсэн юм. Тэгэхдээ хэл нэвтрэлцэнэ гэдэг тун амаргүй асуудал байсан. Тэр болгонд цехийн залуучууд сэтгэлээр унаж байгаа нь илт мэдрэгдэнэ. Тэдэнтэй ойлголцоход ийм бэрх байгаа юм чинь тэдэнд өөрсдөд нь ямар байгаа бол гэж бодохоор хэцүү санагдсан. Тиймээс надад сонсголын бэрхшээлтэй иргэдийг бусадтай ойлголцоход туслах сан, нийгэм сонсохгүй, ойлгохгүй байгааг нь хэлж дамжуулж өгөх сөн гэсэн хүсэл төрж дохионы хэл сурч эхэлсэн. Дээрээс нь, хань маань сонсголын бэрхшээлтэй байсан учир энэ хэлийг илүү хурдан сурахад том түлхэц болсон. Ингэж л анх сонсголын бэрхшээлтэй иргэдэд сайн дураараа тусалж эхэлсэн юм.

Монгол Улсад сонсголын бэрхшээлтэй нийт хэдэн хүн байдаг вэ?

-2016 оны судалгаанаас үзэхэд манай оронд нийт 12 мянган хүн байдаг гэсэн статистик бий. Улаанбаатарт 3000 орчим нь амьдардаг. Дийлэнх нь хөдөө орон нутагт амьдарч байна. Эмзэглүүштэй нь, 12 мянган хүнд хүрч ажиллах дохионы орчуулагч нар маш цөөн. Над шиг дохионы хэлмэрчээр ажилладаг 10 гаруй хүн байдгаас тав нь л нийгэмд илүү хүрч ажилладаг. Үүнээс үзэхэд энэ чиглэлийн мэргэжилтэн маш ихээр дутагдаж байна. Энэ нь манай оронд дохионы хэлийг албажуулаагүйгээс үүдсэн асуудал юм. Дохионы хэлэнд тодорхой стандарт байдаггүй юм гэхэд одоо хэрэглэж байгаа хэлийг нь албан ёсоор баталгаажуулж, кодлон олон нийтэд түгээх хэрэгтэй. Тэгснээр мэргэжлийн индексстэйгээр албан ёсны хэлээрээ ажиллахад дохионы орчуулагч нарын дунд зөв буруу гэсэн маргаан гарахгүйгээс гадна илүү олон боломж нээгдэнэ. Жишээ нь, дохионы хэлийг албажуулснаар сонсголын бэрхшээлтэй иргэдэд боловсрол олгох талд ахиц дэвшил гарах ач холбогдолтой юм.

Өөр шиг тань мэргэжилтэй хүмүүс нэмэгдэх хандлага ажиглагдах юм уу?

-Сүүлийн үед олон

С.Бямбадэлгэр: Би ЭХ ОРНЫХОО ТУСТААР ТӨТТӨНӨД ӨӨРИЙН ХУВЬ НЭМРЭЭ ОРУУЛЖ ЯВАА ГЭЖ БОДДОГ

залуу энэ хэлийг суръя, сонсголын бэрхшээлтэй иргэдэд тус дэм болъё гэж надтай холбогддог болсон. Би үүнд нь их сэтгэл хангалуун явдаг. Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулж дохионы хэлмэрч хийнэ гэдэг багагүй туршлага шаарддаг. Учир нь маш хурдтай байхаас гадна хэнд ч ойлгогдохоор дохио чаддаг байх хэрэгтэй. Үүнд дохионы хэлний үгийн баялаг маш чухал. Дор хаяж 3-5 жил тасралтгүй дадлага, сургуулилт хийх шаардлагатай.

Та манай оронд дохионы хэлмэрчийн мэргэжил эзэмшүүлэх сургалтын систем байдаггүй гэж ярьж байсан. Үүнээс шалтгаалж сонсголгүй иргэдийн эрх ашиг хэр их зөрчигддөг вэ?

-Сонсголгүй иргэдийг хөгжлийн бэрхшээлтэй гэхээсээ илүү хэлний цөөн гэж бид нэрлэдэг. Өндөр хөгжилтэй орнууд сонсголгүй иргэддээ үзүүлэх үйлчилгээгээ бүрэн хуульчилж авч үздэг. Жишээ нь, шүүх, цагдаа, боловсрол, эрүүл мэндийн чиглэлээр үйлчилгээ авахаар сонсголгүй иргэн ирлээ гэвэл хариуцсан хүмүүс сонгогдон ажилладаг. Орчуулагчийн цалинг төрөөс олгож, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ эрхийг хамгаалдаг. Гэтэл манай төр ийм үүрэг гүйцэтгэдэггүй. Манай "Монголын хэлмэрч, орчуулагчдын холбоо" ТББ-ынхан энэ үүргийг дангаараа гүйцэтгэдэг. Сонсголгүй иргэд бидэнд ирж, хэлмэрч, орчуулагчаа сонгож, шаардлагатай үйлчилгээг авч байна. ОХУ-ын Улаан-Үүд хотод сонсголгүй иргэдийн нийгэмлэг гэж бий. Тус нийгэмлэгийнхэн хотынхоо тодорхой тооны сонсголгүй иргэдэд туслах үүрэгтэй бөгөөд төр нь санхүүжүүлдэг. Гэтэл манайд сонсголгүй иргэд төрийн үйлчилгээ авахад үнэхээр хүндрэлтэй байна. Миний ганц мөрөөдөж явдаг зүйл бол заавал сонсголттой, сонсголгүй иргэд гэдгээр нь ялгалгүй бүгд эрх тэгш байгаасай гэж хүсдэг. Энэ тухайд төрөөс хуульчилж өгөх хэрэгтэй.

"Ковид-19" цар тахал дэлхий нийтэд эрчимтэй дэгдсэнтэй холбоотойгоор Эрүүл мэндийн яамнаас цаг үеийн мэдээллийг өдөр бүр дохионы хэлмэрчээр

Оюутан цагаасаа сонсголын бэрхшээлтэй найз нөхдөөсөө дохионы хэлийг сурч, 27 жилийн турш тэдний нийгэмтэй харилцах гүүр, иргэдтэй ярилцах дуу хоолой нь болж явсан цөөн хэдхэн хүний нэг бол С.Бямбадэлгэр юм. "Сонсголын бэрхшээлтэй иргэд бол бусдын л адил хүн, тиймээс тэднийг ямар нэгэн байдлаар ангид үзэх ёсгүй" гэсэн хатуу байр суурь энэ эмэгтэйд илтгэн харуулах мөн чанар гэж ойлгож болно. Хамгийн гол нь манай оронд дохионы хэлмэрч, орчуулагч хэмээх чухал мэргэжлийг аль ч их, дээд сургуульд заадаггүйгээс сонсголгүй иргэдийн эрх нийгэмд зөрчигдөх гол шалтгаан болдогт эмзэглэж явдаг тэр бээр энэ чиглэлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүднээс дохионы хэлмэрчийн ажлыг сайн дураараа хийж иржээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дэргэдэх Сэргээн засах сургалт, үйлдвэрлэлийн төвийн Мэргэжлийн ур чадвар олгох сургуулийн дохионы хэлний багш, МҮОНТ-ийн "Цагийн хүрд" мэдээллийн хөтөлбөрийн дохионы хэлний хөтөлгөчийн ажлыг хийхийн хажуугаар "Монголын хэлмэрч, орчуулагчдын холбоо" ТББ-ын дохионы хэлмэрчээр ажилладаг завгүй амьдралын хэмнэлтэй хүн гэж өөрийгөө танилцуулах түүнтэй хэсэгхэн хугацаанд ярилцлаа.

дамжуулж хүргэх болсон. Шуудхан хэлэхэд таны үүрэг оролцоо их байсныг монголчууд харлаа. Энэ утгаараа нийгэмд сонсголын бэрхшээлтэй иргэдийн асуудлыг нухацтайгаар хүлээж авах ёстой юм гэдэг мессежийг хүргэж чадсан гэж бодож байна?

-"Ковид-19" цар тахлын эхний мэдээллийг дохионы хэлмэрчгүйгээр хүргэсэн. Ингэснээр сонсголгүй иргэд юу болсон тухай мэдэж чадаагүй. Тиймээс холбогдох яам, агентлагаас нийтээрээ анхаарах ёстой чухал

нь эх орноо батлан хамгаалах үйлсэд оруулж таны хувь нэмэр гэж харж, талархаж явдаг. Та энэ талаар ямар бодолтой явдаг вэ?

-Батлан хамгаалах яамны "Соёмбо" редакцын "Дуулга" студийг бэлтгэдэг "Эх орны төлөө" нэвтрүүлэгт миний бие дохионы хэлний хөтөлгөө ажиллаж эхлээд жил орчмын хугацаа өнгөрсөн байна. Энэ төрлийн нэвтрүүлэг сонсголын бэрхшээлтэй иргэдэд маш чухал. Учир нь эх оронч үзлийг бий болгоно гэдэг сонсголгүй иргэдийн хувьд өргөн хүрээний ойлголт юм. Адаглаад эх

соёл, уламжлалаасаа хамаарч өөрийн хэв маягийг агуулдаг. Жишээ нь зулай, зүрхэндээ гар хүргэх нь "Сайн байна уу" гэсэн утгатай. Эртний хаад, ноёдод хүндэтгэл үзүүлэхдээ энэ маягаар дохио, зангаа ашигладаг байсан нь өнөө цагийн дохионы хэлний нэг хэсэг болж үлдсэн гэсэн үг. Дээрээс нь энэ хэл бол сонсголгүй хүний төрөлх хэл. Тиймээс дохионы хэлийг нүдний хараанд суурилсан амьд хэл гэж би хэлэх дуртай. Мөн хүн төрөлхтний анхдагч хэл гэж судлаачид үздэг. Анх хүмүүс хоол идэх, ус уух,

мэдээлэл хүргэж буй учир дохионы хэлний орчуулагч ажиллуулах нь зүйтэй юм гэсэн шийдвэр гаргасан. Тиймээс өнгөрсөн оны 1 дүгээр сарын 27-ноос эхлэн сонсголгүй иргэдэд чиглэсэн байдлаар дохионы хэлмэрчтэйгээр мэдээллийг олон нийтэд хүргэж эхэлсэн. "Ковид-19" цар тахлын тухай мэдээллийг дохионы хэлмэрчтэйгээр улс орон даяар шууд нэвтрүүлж байгаа нь манай улсын хувьд

орныхоо хөгжил цэцэглэлтэд би ямар хувь нэмэр оруулж болох вэ гэсэн бодлыг тэдэнд төрүүлдэг. Том жижиг зэвсэгт мөргөлдөөн, цаашлаад дайн байлдаан болвол иргэн бүр үүрэг оролцоотой байх ёстой юм байна гэсэн ойлголтыг төрүүлж чаддаг гэж бодож байна. Миний хувьд эмэгтэй хүн хэдий ч эх орныхоо тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлыг хангахад өөрийн мэргэжил, чадвар, сэтгэл

араатан амьтнаас болгоомжлох үедээ хоорондоо дохионы хэлээр харьцдаг байсан нь дуу авиагаар солигдож, улмаар бидний хоорондоо харилцдаг хэл үүссэн хэрэг.

Дохионы хэлмэрч, орчуулагч гэдэг хэр хүнд мэргэжил вэ?

-Барууны орнуудад дохионы хэлмэрчийг онгоцны нисгэгчийн дараа орох хүнд мэргэжил гэж үздэг. Хурдтай сэтгэн бодох чадвараас



Эх орныхоо хөгжил цэцэглэлтэд би ямар хувь нэмэр оруулж болох вэ гэсэн бодлыг тэдэнд төрүүлдэг. Том жижиг зэвсэгт мөргөлдөөн, цаашлаад дайн байлдаан болвол эх орныхоо төлөө иргэн бүр үүрэг оролцоотой байх ёстой юм байна гэсэн ойлголтыг төрүүлж чаддаг

дэвшил болж чадсан. Миний харж байгаагаар олон нийтийн хандлага ч өөрчлөгдөж байна. Энэ эерэг хандлага хойшид ч гэсэн үргэлжилсээр байвал сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулсан шаталсан хөтөлбөрүүдийг бий болгож, боловсорч хөгжих талаар илүү зөв зохистой, санал санаачилгыг бий болгох шаардлага үүсэж эхэлнэ гэж бодож байна.

Та "Эх орны төлөө" нэвтрүүлгийн дохионы хэлний хөтөлгөөр давхар ажилладаг. Цэрэг, эх орны сэдэвтэй нэвтрүүлгийг дохио

зүрхээрээ дэмжлэг үзүүлж, Монгол Улсын өмнө хүлээсэн иргэний үүргээ биелүүлж байна гэж ойлгож хичээж ажилладаг.

Улс болгон өөр өөрийн дохионы хэлтэй байдаг гэж сонссон. Монгол дохионы хэлний онцлог юу вэ?

-Дохионы хэл гэдэг өөрөө орчин, нийгэмдээ зохицож байнга хувьсан өөрчлөгддөг онцлогтой. Дээрээс нь тухайн үндэстний өв уламжлал, соёл, шашин шүтлэгээс хамаарч улс орнуудын дохионы хэл өөр байдаг. Олон улсын дохионы хэл ч гэж бий. Монгол дохионы хэл яг үүнтэй адил

гадна өргөн хүрээний мэдлэг шаарддаг. Өөрөөр хэлбэл, ямар чиглэлийн мэдээллийг хүргэх гэж байна вэ гэдгээ сайтар судалсны дараа тухайн чиглэлийн хэллэгийг хоногшуулах хэрэгтэй. Тэгж байж хүмүүсийн сэтгэхүйд буулал дүрсэлж чадна. Миний хувьд ажлын шаардлагаас үүдэн чөлөөт цагаараа ном их уншиж, мэдлэгийнхээ хүрээг тэлдэг. Зарим тохиолдолд найзуудаасаа зөвлөгөө авдаг. Түрүүнд хэлсэнчлэн цаг үетэйгээ уялдан байнга өөрчлөгдөж байдаг хэл учир сурахад амар хэл биш.

ОЛОН УЛСАД ЦЭРГИЙН МЭРГЭЖЛИЙН САЛБАРТ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦОО НЭМЭГДЭЖ БАЙНА

М.МӨНХЗОРИГ

Хүн төрөлхтний түүхийн олон нугачаанд эмэгтэй цэргийн үүрэг оролцоо өндөр байсаар иржээ. Тэд дайн тулалдаанд оролцож, эгэл жирийн цэргээс жанжин болтлоо дэвшсэн нь ч бий. Дэлхийн I дайн хүртэл эмэгтэйчүүд цэрэгт зөвхөн ар

даах ёстой. АНУ, Их Британи, Канад зэрэг улс эмэгтэй цэргийн алба хаагчдынхаа тоог эрчимтэй нэмэгдүүлэх бодлого барьж байна. Тэр дундаа Канад энэ талын эрх зүйн орчныг маш сайн бүрдүүлж, жендерийн эрх тэгш байдлыг ямар ч улсаас илүү нэвтрүүлжээ. Тус улс хамгийн сүүлд шумбагч онгоцны



тал, эмнэлгийн чиглэлээр мэргэшдэг байв. XX зуун гарсаар цэргийн шинжлэх ухаанд үсрэнгүй дэвшил гарч, эмэгтэйчүүдийн дайны талбарт гүйцэтгэх үүрэг оролцоо түүхэнд байгаагүйгээр нэмэгджээ. Тэд нисэх онгоц, тагнуул, холбоо, бичиг хэрэг зэрэг олон чиглэлээр үүрэг гүйцэтгэх болсон байна.

Тухайлбал, Дэлхийн I дайнд ЗХУ зөвхөн эмэгтэйчүүдээс бүрдсэн батальон байгуулж байжээ. Сайн дурын үндсэнд эх орныхоо төлөө тулалдахаар шийдсэн эмэгтэйчүүдээс бүрдсэн тэдгээр цэрэг фронтын тэргүүн шугамд эрчүүдээс дутахааргүй ялалт авчирдаг байсан аж. Тэдний үүрэг оролцоо, үзүүлсэн амжилт эрчүүдийг цэрэгт татахад маш том сурталчлага болдог байв. Нөгөөтэйгүүр эмэгтэйчүүд фронтод байлдаж байгаа нь эрчүүдэд гутамшигтай санагдаж, эх орныхоо төлөө тулалдах урам зоригийг хамгийн ихээр өдөөдөг байжээ.

Испанийн иргэний дайнд мянга мянган эмэгтэй оролцож, амь насаа алдсан түүхтэй. Харин Дэлхийн II дайнд Англи, Германы ойролцоогоор 100 мянга гаруй эмэгтэй агаарын довтолгооноос хамгаалах анги, нэгтгэлд алба хааж, дайсны мянга мянган онгоцыг унагаж байсныг түүх гэрчилнэ. Европын орнуудын армид цэргийн шинжлэх ухаан, технологи хөгжихийн хэрээр эмэгтэйчүүдийн гүйцэтгэх үүрэг ч нэмэгдэж эхлэв. Түүнчлэн Дэлхийн II дайны үед аж үйлдвэрийн хөгжил маш хурдацтай явагдаж, үйлдвэрлэл өргөн цар хүрээтэйгээр нэмэгдсэн бөгөөд эмэгтэйчүүд олон арваараа цэргийн техникийн үйлдвэрт ажиллах болов. Тэд сум, галт хэрэглэл, танк, явган цэргийн байлдааны машин, хөлөг онгоц, нисэх онгоцны үйлдвэрт маш өндөр ачаалал авч, өдөр шөнөгүй ажилладаг байв.

Мөн авран хайх, гал унтраах, автомашины жолооч, барилгын инженер зэрэг албанд дайчлагдах болов. Энэ цагаас эрэгтэйчүүд л зөвхөн ажил хийж, мөнгө олдог гэсэн хэвшмэл ойлголт арилж, үүнийг дагаад эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах үйлдвэрчний эвлэлүүд олноор байгуулагдаж, тэдний нийгэмд эзлэх байр суурь ч нэмэгдэв. Өмнө нь зөвхөн эрчүүд хийдэг нарийн мэргэжлийн ажлыг эмэгтэйчүүд хийх болсноор эрчүүдээс өндөр цалин авдаг болов.

XXI зуун гарснаар эмэгтэй цэргийн алба хаагчдын эзлэх хувь олон улсад харилцан адилгүй байна. Тухайлбал, Энэтхэгт 3, Их Британид 15, Францад 13, Шведэд 14, АНУ-д 16, Канадад 15.3, Өмнөд Африкт 27 хувийг тус тус эмэгтэй цэргийн алба хаагчид эзэлж байна. Шинжээчдийн үзэж байгаагаар Өмнөд Африкийг эс тооцвол олон улсад эмэгтэйчүүдийн эзлэх хувь хэмжээ Дэлхийн II дайны үеийнхтэй харьцуулахад тийм ч их нэмэгдээгүй гэж үзэж байна. Тэд цэргийн алба хаах нь эрчүүдийн сэтгэл зүйд сайнаар нөлөөлдөг. Мөн эрчүүдтэй адил ачаалал үүрч, дасгал сургуулилт хийх нь эмэгтэйчүүдэд өөртөө итгэх итгэлийг төрүүлдэг гэж үздэг байна.

Зарим оронд тэднийг байлдааны тэргүүн шугамд үүрэг гүйцэтгэхийг зөвшөөрдөг тусгай анги, нэгтгэлүүд байдаг. Гол нь эрчүүдийн нэгэн адил сургалт бэлтгэлийн ачааллыг

экипажийн ажлын байрыг нээлттэй болгожээ. Гэхдээ Норвегийн Тэнгисийн цэрэг нь түүхэндээ анх удаа шумбагч онгоцонд ажиллах эмэгтэйчүүдийн албан тушаалыг баталсан орноор тооцогддог юм. Түүгээр зогсохгүй хамгийн анхны шумбагч онгоцны эмэгтэй даргаар ахмад Солвег Крэй 1995 онд томилогдож байжээ. Дараа нь 1988 онд Швед, 1989 онд Дани, 1998 онд Австрали, 2000 онд Канад, Испани, 2010 онд АНУ, 2014 онд Британичууд эмэгтэйчүүдийг шумбагч онгоцонд ажиллахыг зөвшөөрчээ. Шумбагчийн экипажид эмэгтэй хүнийг "амьдруулах"-ын тулд тусгай нөхцөл шаарддаг. Тэдний амралтын байрыг эрчүүдээс тусад нь шийддэг бөгөөд зөвхөн нэг амралтын байр гэхэд 300 мянган ам.доллаар босдог ажээ.

АНУ-ын хувьд ч мөн ялгаагүй цэргийн ихэнх албан тушаал эмэгтэйчүүдэд нээлттэй байдаг. Ялангуяа сүүлийн жилүүдэд тусгай хүчинд ажиллах эмэгтэйчүүдийн тоо нэмэгдэж байна. Тухайлбал, тус улсын 1.1 сая хуурай замын цэргийн 15.6 хувийг эмэгтэйчүүд эзэлдэг. 2013 оны байдлаар хуурай замын цэргийн тусгай мэргэжил болох гар хийцийн тэсрэх бөмбөгийн мэргэжилтэн, биометрийн шинжээч, тактикийн удирдлага зэрэг албан тушаалд эмэгтэйчүүд ихээр ажиллах болжээ.

Рейнжерийн сургуульд 2015 онд 19 эмэгтэй суралцсанаас эхний шатанд 11 хүн, хоёрдугаар шатанд таван хүн, гуравдугаар шатанд нэг хүн тус тус хасагдаж, хоёр эмэгтэй анх удаа тус сургуулийг төгссөн байна. Энэ нь эрчүүдэд ч бэрх тооцогддог сургалтыг эмэгтэйчүүд даван гарч чаддаг гэдгийг нотлон харуулсан явдал болов. 2019 онд АНУ-ын Сансрын цэрэг бий болсноос хойш эмэгтэйчүүдийн эрх, тэгш оролцоог хангахын тулд маш их анхаарч ажиллаж байна. Тиймдээ ч сансрын ажиллагааны удирдлагын даргаар дэслэгч генерал Нина Армагног өнгөрөгч 8 дугаар сард томилжээ.

Исламын шашинтай орнуудаас зөвхөн Пакистан л эмэгтэйчүүдийг армид удирдах өндөр албан тушаалд ажиллахыг зөвшөөрдөг. Мөн тусгай хүчин, тагнуулын тодорхой албан тушаалд тэднийг томилдог. Пакистан Улс байгуулагдсан цагаасаа хойш Үндэсний Зэвсэгт хүчний тухай хуульдаа эмэгтэйчүүдийн оролцоог тодорхой зааж өгснөөр тус улс нь жендерийн эрх тэгш байдлыг батлан хамгаалах салбартаа хамгийн сайн хангасан исламын шашинт улс болоод байна.

Австрали улс ч мөн ялгаагүй цэргийн мэргэжлийн албан тушаалуудад эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхийг зорьж байна. 2001 онд батлагдсан Батлан хамгаалахын хуулийн дагуу тусгай хүчин, артиллери, явган цэргийн зарим албан тушаал нээлттэй болж, эмэгтэйчүүд нийт ажлын байрны 95 хувьд ажиллахад саадгүй болсон юм. Тус улс НАТО-гийн гишүүн орон биш ч Афганистанд цэрэг хандивлагч орнуудыг тэргүүлдэг. Түүгээр ч зогсохгүй Афганистанд эмэгтэй цэргүүдээ хамгийн олноор илгээсэн орнуудын жагсаалтад АНУ-ын дараа ордог ажээ.

Зэвсэгт хүчин хэмээх их айлд "бүл нэмж", эрчүүдтэй мөр зэрэгцэн алба хааж яваа мөрдэс гоёсон цэргийн бүсгүйчүүдийн төлөөлөл болох Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн хорооны удирдах байрын тасгийн дарга, ахлах ахлагч М.ЦОЛМОНТОЙ ярилцлаа.

Д.МЭНДБАЯР

Юуны өмнө Танд удахгүй тохиох Олон улсын эмэгтэйчүүдийн баярын мэндийг хүргэе.

-Баярлалаа. Мөрдэс нэгт нийт сайхан бүсгүйчүүдээ баярын мэндийг дэвшүүлье. Мөн сонинхоо ярилцлагын хойморт урьж, Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнтэй, тэр тусмаа мөрдэс гоёсон цэргийн бүсгүйчүүдтэй баярын энэ үеэр уулзуулж байгаа танай хамт олонд баярлалаа.

БИДНИЙ НЭГ



ЭХ ОРНОО ГЭСЭН АГУУ ХАЙР СЭТГЭЛИЙН ЧАНАДААС АЯНДАА АСГАРДАГ

Таныг уншигчдадаа танилцуулахаас ярилцлагаа эхэлье ...

-Би 1978 онд Сүхбаатар аймгийн Баруун-Урт суманд төрсөн. Моонхүүгийн хэмээх эгэл жирийн айлын ууган охин. Мэдээж ижий аавынхаа гар дээр өсөж торниод, 1995 онд аймгийнхаа 10 жилийн нэгдүгээр сургуулийг төгссөн. Тэгээд 1997 оны 9 дүгээр сард Зэвсэгт хүчний 124 дүгээр ангийн радио чимээний дамжаанд суралцаж төгсөөд тус ангидаа радиотелеграфчинаар ажлын гараагаа эхэлж байлаа.

Зэвсэгт хүчинд алба хаах хөшүүрэг нь юу байсан бэ?

-Тухайн үед цэргийн дүрэмт хувцастай ах эгч нар маш гоё харагддаг байлаа. Цаанаа л нэг тийм бахархмаар. Тэгээд 10 дугаар анги дүүргээд сэтгэлийн дуудлага, эрс шийдвэрээр цэргийн хүн болох шангаа татаж дээр дурдсанчлан дамжаанд суралцаж, Зэвсэгт хүчний халуун ам бүлд багтсан.

Цэргийн бүсгүй байхын сайхан бөгөөд хүнд хэцүү нь юунд оршдог гэж та тодорхойлох вэ?

-Хүнд хэцүү гэхээсээ баярлаж бахархмаар, омогшиж онгирмоор чанар их. Аливаа хэцүү бэрхийг даван туулах сэтгэлийн хат, тэсвэр тэвчээр, шантаршгүй зориг, ажлын гүйцэтгэл, амьдралаа дэнслэн авч явах арга ухаан, хувийн зохион байгуулалт гээд дурдаад байвал бусдаас ялгарах чухал чанар олон. Угаасаа Зэвсэгт хүчин ингээд ургагчид гэх ч хэлж болно. Гэрийн сайн эзэгтэй, сайн ээж байхыг хичээдэг боловч тэр бүр төгс байж чаддаггүй нь цэргийн бүсгүйчүүдийн дутагдалтай тал гэж өөлж болох юм.

Яагаад ч юм танаас халирч шантарч байсан уу гэж асуух илүүц санагдаад явчихлаа. Ярианаас тань нэг тийм эрч хүч мэдрэгдээд ...

-Тийм гэх үү, баярлалаа. Надад шантарч явсан үе олон бий. Гэсэн ч ухрах тухай огт бодож байгаагүй.

Тухайлбал ...

-Цэргийн хүний хувьд энхийг сахиулах ажиллагаанд оролцож, цэнхэр дуулгат дайчдын эгнээнд элсчих юм сан гэсэн мөрөөдлийг би цөөнгүй жил тээсэн юм.

Тэрхүү хүсэлдээ хөтлөгдөн 2014 онд энхийг сахиулах үйлсэд оролцохоор шийдэв. Тэгээд олон аав ээжийн охид хөвгүүдтэй сонгон шалгаруулалтад оролцож тэнцээд бэлтгэлд гарлаа. Ажиллагааны өмнөх бэлтгэл амар байгаагүй, 10 км-ийн гүйлт, 30 км-ийн явган марш бас л чанга шүү. Зүгээр нэг сул алхалт бишийг маныхан сайн мэднэ. Тэр үед л шантарч байлаа. Ерөөсөө буцъя, мөрөөрөө ажлаа хийе гэсэн бодол эрхгүй төрсөн. Тэр үед урмын үг ямар их хүч тэнхээ, зориг тэвчээр, өөртөө итгэх итгэл өгдгийг хамгийн ихээр ойлгосон.

Хамгийн хүчтэй зэвсэг бол үг гэдэг дээ?

-Яг тийм, амины нэг найзынхаа "Чи л чадахгүй бол өөр хэн чадах вэ" гэсэн үгнээс маш их итгэл, хариуцлагыг мэдрэсэн. Тиймдээ ч өөрийгөө зоригжуулан бэрхшээлийн ард гарч, энхийг сахиулагчдын жагсаалд нэгдэж чадсандаа баярлаж, бахархах сэтгэл төрдөг. БНӨСУ-д явагдаж байгаа НҮБ-ын "UNMISS" ажиллагаанд хоёр удаа буюу дөрөв, есдүгээр ээлжид үүрэг гүйцэтгэсэн. Энэ дашрамд хоёр багийнхаа удирдлагууд, хамт олонд талархаж явдгаа илэрхийлье. Мөн үе үеийн цэнхэр дуулгат бүсгүйчүүддээ, тэр тусмаа мөр зэрэгцэн үүрэг гүйцэтгэсэн бүх сайхан бүсгүйчүүддээ баярын мэнд дэвшүүлж, ажлын амжилт, амьдралын гэгээн бүхнийг хүсэхэд таатай байна. Цэргийн бүсгүйчүүд бид чинь бусдад тэсвэр хатуужлын оргил мэт ойлгогддог ч эмэгтэй хүмүүс л юм хойно хүний газар очоод хайртай гэр бүл, ижий аав, үр хүүхдээ их санана, зовлон жаргалаа хуваалцана, сүүлдээ бидний ярьдаг сэдэв ердөө хүүхэд болчихдог. Үрсийнхээ тухай ярилцаад уйлна, инээлдэнэ ер нь хөгтэй зүйл их болно оо.

Яг тэгдэг шүү. Дээр нь ажиллагаанд үүрэг гүйцэтгээд ирсэн хүний эх орноо хайрлах сэтгэл, харах өнцөг их өөрчлөгддөг юм билээ ...

-Тэгэлгүй яах вэ, эх орныхоо үнэ цэнийг чинээнд нь тултал мэдэрдэг. Өөрийн эрхгүй ямар их хувь зохиолоор монгол хүн болж төрсөн юм бэ, ямар их аз ивээлээр ийм тансаг эх орны эзэн заяанд төрөө өө

гэж бодогддог. Тэр хэрээр эх орноо гэсэн хайр сэтгэлийн чандаас аяндаа асгардаг.

Таны бахархал юу вэ?

-Эх орон, ээж аав, гэр бүл минь.

Таны залуу хойч үеэ сурган дадлагажуулахад зүтгэлтэй ажиллагчийг мэдэх юм...

-Ажлын дадлага туршлага, арга барил, мэддэг чаддагаасаа бага гэлтгүй аль болох бусадтай хуваалцахыг хичээдэг. Дөнгөж ажлын талбарт хөл тавьж байгаа залууст сурч мэдсэн зүйлээсээ хэлж заагаад өгчих юм сан гэсэн сэтгэлээр ханддаг. Өөрөө ч ахмад үеэсээ суралцаж, тэднээсээ үлгэрлэж ажилдаа хөлөө олж байлаа. Залуу үеийнхнийг сургаж бэлтгэхэд чадлынхаа хэрээр хувь нэмрээ оруулах ёстой гэж ойлгодог. Миний удирдлагад ажилладаг радиотелеграфчинд ахлагч А.Цолмон, Б.Өлзийбуян, Ц.Гантогтох, М.Ариунтуяа, Э.Цэрэнлхам гээд залуус маань нэг талаасаа шавь нар минь юм.

Ажил мэргэжлийнхээ онцлогийг тодотгооч?

-Эх орныхоо агаарын дархан хилийг манана гэдэг бидний мэргэжлийн онцлог. Бидний хамгийн том бахархал.

Таны амьдралдаа баримталдаг зарчим юу вэ?

-Зөв бодолтой, аливаа зүйлд чин сэтгэлээсээ ханддаг байхыг гол зарчмаа болгодог. Зөв бодол өөрөө зөв бүхний эхлэл байдаг.

Шүүмжлэлтэй ханддаг зүйл тань юу вэ?

-Цэргийн дүрэмт хувцсыг, ялангуяа эрээн хүрмийг хэн дуртай нь ажлын хувцас шиг өмсдөг. Үүнд маш шүүмжлэлтэй ханддаг. Энэ бол төрийн хувцас. Бид ч ажлын бус цагаар өмсөөд гадуур холхиод байдаггүй биз дээ.

Сүүлийн асуултыг таны мэдэлд үлдээе. Уншигчдад хандаж юу хэлэх вэ?

-Эх орноо батлан хамгаалах их үйлсэд хүчин зүтгэж, залуу халуун нас, сэтгэл оюунаа зориулсан Зэвсэгт хүчнээр овоглогдсон бүх хүмүүст Зэвсэгт хүчний 100 жилийн ойн мэндийг дэвшүүлье.

Р.Өнөржаргал: дууныхаа үгийг энхийг сахиулагч бүсгүйчүүдээ бодож бичсэн

Х.ГАНЗУЛ

Энэ дууг мөрдөстэй бүсгүй бүр сонсох дуртай. Уг бүтээл хэрхэн бүтсэн тухайд шүлгийг тэрлэсэн ЦДБЭЧ-ын Сургалт, соёл хүмүүжил, маркетингийн албаны дарга, дэд хурандаа Р.Өнөржаргалаас тодруулсан юм

“Зэвсэгт хүчний 90 жилийн ойгоор Цэргийн сэдэвт дууны улсын уралдааныг зохион байгуулсан. Энэ тухай хөгжмийн зохиолч Б.Мөнхжаргалд хэлтэл хоёулаа оролцъё гэдэг юм байна. Хань минь энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байсныг ч хэлэх үү, нэлээд уянгын шүлэг бичиж өглөө. Удалгүй Гаалийн байгууллага үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойн арга хэмжээг хөтөлж байтал гэнэт залгаад “Найзаа сайхан шүлэг байна. Гэхдээ хэтэрхий гунигтай талдаа юм. Цоглог, бадрангуй, хөгжүүн дуу баймаар байна” гэлээ. Тэгээд л тайзны ард шүлгээ бичсэн дээ. Б.Мөнхжаргалын “Хөгжүүн бадрангуй” гэж хэлэхтэй зэрэгцээд анхны эмэгтэй энхийг сахиулагчид болох хурандаа Н.Нямжаргал, Г.Болор нар сэтгэлд шууд буусан. Тэдний эгэл зөөлөн төрх, хатуу зарчимч чанар хамгийн түрүүнд тодорсон.



сахиулах ажиллагаа дахь эмэгтэйчүүдийн оролцоог тодотгож өгсөн юм. Дууг маань анх Цагдаагийн “Сүлд” чуулгын дуучин н.Нарангэрэл гэж жагсаалын чимэг болсон бүсгүй дуулсан. Гурван эмэгтэй уран бүтээлчийн сэтгэлээс бүтсэн болохоор “Бүсгүй дуу” гэж нэрлэх дуртай. Одоог хүртэл дуулагдаж мөрдөстэй бүсгүйчүүд төдийгүй олон түмний дуулах, сонсох дуртай бүтээл болсонд баяртай явдаг” гэж бүтээлийнхээ тухай дэд хурандаа Р.Өнөржаргал бяцхан түүх хуучиллаа.

Түүнчлэн БНАСАУ-д зохион байгуулагддаг “Хаврын баяр” наадмаас ЦДБЭЧ-ын эмэгтэй уран бүтээлчид “Алтан цом” хүртэж тэр шагналынхаа мөнгөөр “Мөрдс гөёсон” цэргийн бүсгүй”, “Жагсаалын цэрэг дайчин бүсгүй” дууны клипийг хийхээр санаа нэгдсэн аж. Клипний зураг авалтад зохиогч давуу талаа “ашиглаж”, хань, хүү, ээж аавуудаа оруулсан боловч нэг л мэдэхэд энхийг сахиулагч бүсгүйчүүдийн үүрэг гүйцэтгэхээр мордох мөч, эх орондоо ирж буй сэтгэл догдлом агшнуудаас клип нь бүтчихсэн тухай хөгжилтэй түүхээсээ ч хуваалцаж жагсаалын чимэг дайчин бүсгүйчүүддээ баярын мэнд дэвшүүлснийг уламжилъя.

Сүүтэй энгэртээ алдрын одонтой Дуутай жагсаалдаа энхрийхэн дүртэй Бүрэн заяат улсынхаа төлөө Бүтэн амьдралаа зориулж зүтгэсэн Жаргалтай орны жавхаалаг бүсгүй Жагсаалын чимэг дайчин бүсгүй Тэнгэрлэг эрстэй мөр зэрэгцэн Тив дэлхийгээ хамгаалж явна аа

Нартай хорвоодоо хатан заяатай Нарлаг монголдоо айрын тангарагтай Бүүвэйн дуутай үрсийнхээ төлөө Бүхий л сэтгэлээ зориулж зүтгэсэн Жаргалтай орны жавхаалаг бүсгүй Жагсаалын чимэг дайчин бүсгүй Тэнгэрлэг эрстэй мөр зэрэгцэн Тив дэлхийгээ хамгаалж явна аа

Сартай шөнөөр ч соргог манаатай Сайны төлөө мөнхийн харуултай Цэнхэр гарагийнхаа энхийн төлөө Цэцгийн дэлбээг ч хайрлан өмгөөлсөн

Тийм ч учраас **Тэнгэрлэг эрстэй мөр зэрэгцээд Тив дэлхийгээ хамгаалж явна аа** гэсэн мөртөөрөө энхийг

ГЭРЭЛ ЗУРАГ ТҮҮХ ӨГҮҮЛНЭ



Зүүн гар талаас: Д.Ганболд, Д.Энхбаяр, Г.Батжаргал, Д.Батсүх, Б.Жуваа, Д.Баатар, Б.Отгонбаяр, Д.Чулуунбаатар, О.Өсөхбаяр

Сүхбаатарын болон Байлдааны гавьяаны улаан тугийн одонт Цэргийн ерөнхий дээд сургуулийн Д.Давааням, Ц.Эрдэнэ захирагчтай улс төрийн курсийн 1979 онд төгссөн төгсөлтийн хамт олондоо болон ерөнхий цэрэг, артиллери, холбоо,

авто инженерийн мэргэжлээр төгссөн онжавууддаа Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэж байгуулагдсаны 100 жилийн ойн халуун мэндийг хүргэж, хамгийн сайн сайхан бүхнийг хүсье.

Бэлтгэл ахлах офицер Д.ЭНХБАЯР

Бин

(Сургамжит өгүүллэг)

Нэгэн ядуу энэтхэг эмэгтэй өдөр бүр хоёр ширхэг бин хайрдаг байжээ. Нэгийг нь гэр бүлийнхэндээ, нөгөөг нь цонхны тавцан дээрээ тавиад хэрэгтэй нэг нь аваг гэж орхидог байлаа. Бин хайрч байх үедээ илүү сайхан амьдрал хайн гэрээсээ явсан хүүгийнхээ төлөө өдөр бүр залбирдаг байжээ. Хүүгийнхээ тухай олон сар сураг сонсоогүй тул эрүүл саруул эргэн ирээсэй хэмээн залбирдаг байжээ.

Удалгүй түүний хайрсан бинг нэгэн ядарсан бөтгөр эр байнга ирж авч явахыг анзаарчээ. Бинг аваад явахдаа нөгөө эр талархлын үгний оронд “Хийсэн нүгэл чинь чамд үлдэж, буян чинь эргэж ирэг” гэж буйтнана. Энэ үгээ өдөр бүр хэлнэ. Хэзээ ч баярлаж талархсан үг хэлэхгүй байсан тул эмэгтэй дургүй нь хүрэх болжээ. “Өдөр бүр нэг л үг хэлэх юм. Юу ч гэсэн үг юм” гэж дургүйлхэнэ.

Нэг өдөр эмэгтэй энэ бүхнийг зогсоохыг хүсжээ. “Энэ дургүй хүрэм бөгрөөс салах минь” гэсэн бодол төржээ. Тиймээс бин дотроо хор хийж орхив. Гэвч цонхны тавцан руу бариад явж байхдаа гэнэт гар нь салгалж “Би юу хийж байна вэ” гэж боджээ. Хортой бинг хурдхан гал руу хийгээд дахин шинэ бин хайрч гэнэ.

Бөтгөр эр бинг аваад явахдаа нөгөө л үгээ хэлжээ. Тэр эмэгтэйд чичирч зогсохыг анзаарсангүй.

Тэр үдэш хэн нэгэн хаалгыг нь тогшив. Эмэгтэй хаалгаа нээтэл босгон дээр нь хүү нь зогсож байх нь тэр. Турж эцээд ядарч туйлдсан хүү хүн харахын эцэсгүй болжээ. Өмсөж зүүсэн нь хүртэл урагдаж ноорчээ.

“Ээж ээ. Би энд байгаа нь ид шид л гэсэн үг. Би эндээс ганцхан бээрийн зайд явж чадахаа болиод ухаан алдаж унасан юм. Хэрэв миний дэргэдүүр нэгэн хөгшин бөтгөр эр явж өнгөрөөгүй бол үхэх байсан биз. Тэр надад сайхан сэтгэл гаргаж бүтэн бин өгөөд “Энэ миний өнөөдрийн идэх байсан бүх хоол минь боловч чамд илүү хэрэгтэй бололтой” гэж хэлсэн.

Энэ үгийг сонссон ээжийн царай цонхийн цайж унах дөхсөн тул хана түшиж авав. Тэр хортой бингийн тухай санажээ. Хэрэв тэр бинг шатаагагүй бол төрсөн хүү нь үхэх байж. Тэр мөчид нөгөө бөтгөр эрийн хэлдэг “Хийсэн нүгэл чинь чамд үлдэж, буян чинь эргэж ирэг” гэсэн үгний утгыг ойлгожээ.

Хэн ч үнэлэхгүй байсан ч үргэлж сайн үйл хийхийг хичээ.

МӨНХИЙН БЕСТСЕЛЛЕР

FranklinCovey MONGOLIA EDUCATION Монгол хүн 3030 сан

20% ХАМГИЙН ХӨГЖИЛ

7 ДАДЛЫН ГАЙХАМШИГ

ӨНДӨР БҮТЭЭМЖТЭЙ 7 ХҮМҮҮСИЙН ДАДАЛ

Стефен Р. Кови

Дэлхийг ГЭРЭЛТҮҮЛНЭ

ЭЦЭГ, ХҮҮ КОВИ НАРЫН БҮТЭЭЛЭЭС

Стефен Р.Кови

Стефен М.Р.Кови

Шонн Кови

80 ХЭЛ ДЭЭР КОВЕГДСОН

2019 ОНД ТАЙМ СЭТГҮҮЛЭСЭН БИЗНЕС МЕНЕЖМЕНТИЙН ХАМГИЙН БИРЭГ БҮЛЭГ 25 НОМЫН НӨСӨР ВАЛГАРУУЛСАН

50 САР % БОРИРДСОН

4000 НОМ НЬ 2.5 САР ХҮВЬ БОРИРДСОН

ХОЛБОО БАРИХ

89002329, 70140100 info@frankincovey.mn FranklinCovey Mongolia frankincovey.com, www.theleaderinme.org

Сэтгэлийн өнгө

ХОЛБООЧИН БҮСГҮЙ

- Уртын дууныхаа аялгуут айзмаар
- Урт богино үелзэлтэй долгионуг
- Үүлэн тэнгэрээ хээлэн уянгалуулсан
- Уран-гоо гартай холбоочин бүсгүй
- Морзын цагаан толгойн хурдаар
- Монгол Улсаа агаараас хамгаалсан
- Морьтон ардын босоо хийморьтой
- Монголжингоо цэрэг бүсгүй
- Алдаж эндэх эрхгүй албатай
- Андгай тангарагтаа чин үнэнч
- Агаарын долгионы хурдны ангууч
- Ардын цэргийн тагнуулч бүсгүй
- Агаар мандлын тагнуулч бүсгүй
- Ажил нь нууцлаг холбоочин бүсгүй
- Армийн жагсаалын цэрэг бүсгүй
- Агаарын долгионы "Мастер" бүсгүй

Т.ДАШДЭЛЭГ



АЧИТ ЭЭЖ МИНЬ

- Ангир уургаа хөхүүлсэн
- Алдарт одонтой ээж минь ээ
- Аав бидэнд түшиглэдэг
- Ашдын заяатай ээж минь ээ
- Аагтай цайгаа сүлсэн
- Ачит буурал ээж минь ээ
- Аягатай сүүгээ өргөсөн
- Амин хайртай ээж минь ээ
- Ааруул эзэгий хатаасан
- Ариун гартай ээж минь ээ
- Амьдрал жаргалд хүргэсэн
- Ачтай буянтай ээж минь ээ
- Зүүн хоймороо эзэлсэн
- Зүрхний хайртай ээж минь
- Зүүд нойронд хоногшсон
- Зууны хайртай ээж минь ээ
- Аргал хомоол хормойлсон
- Ажилч хичээнгүй ээж минь ээ
- Айраг гараг исгэсэн
- Амтат идээтэй ээж минь ээ
- Холын эрдэмд шамдуулсан
- Хосгүй ухаант ээж минь ээ
- Хоёргүй сэтгэлээр өсгөсөн
- Хорвоогийн хүнлэг ээж минь ээ
- Үүрийн цагаан гэгээнээр
- Үрээ хөхүүлсэн ээж минь ээ
- Үдшийн саруул бүрийгээр
- Сүргээ хотлуулдаг ээж минь ээ
- Буянтай бор нагацаа
- Байнга хүндэлдэг ээж минь ээ
- Борхон ойрхон овоондоо
- Цацлаа өргөдөг ээж минь ээ
- Хол ойрын гийчдэд
- Найрсаг ханддаг ээж минь ээ
- Хурга ишгээ амлуулж
- Хүүгээ өсгөдөг ээж минь ээ
- Өтөг бууцаа цэвэрлэж
- Хурайлж өсгөдөг ээж минь ээ
- Тулга пийшингээ галлаж
- Гэрээ дулаалдаг ээж минь ээ

Ц.ТӨВӨӨ

СОЁМБО СОНИН

“Соёмбо” сонин 97 дахь жилдээ хэвлэгдэж байна.

Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА, Д.НАЦАГДОРЖ

Дарга, ерөнхий редактор Хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ

Эхийг “Соёмбо” сонины редакцияд бэлтгэж, “Соёмбо принтинг” хэвлэх үйлдвэрт хэвлүүлэв.

*Зар, рекламьг хямд нийтэлнэ.

*Зар, рекламьн үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.

*Зохиогчийн үзэл болон сонины нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.

*Тус сонины мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс 10018

И-мэйл хаяг: Soyombo@mod.gov.mn

Утас: 70001029